

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-3

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 4-31

1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./	4-18
2.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	18-31

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
07 дугаар сарын 03-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 24 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аубакир, С.Ганбаатар, М.Мандхай, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Лүндэг, З.Мэндсайхан.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, мөн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Усны газрын дарга З.Батбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын зөвлөх И.Баттөгс нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Б.Уянга, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат,

Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Д.Мөнхбаатар нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хоёр.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Ж.Батжаргал, Б.Уянга, Ц.Мөнхбат, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаясгалан, Г.Ганбаатар, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, Усны газрын дарга З.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, М.Ганхүлэг, Б.Уянга нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүсэд” гэсний дараа “инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга, байгууламжаас бусад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Найдалаагийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 73.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Мал эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга Т.Балжинням, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Батбаатар, Д.Гантулга, судлаач Г.Сувдаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Тогтоолын төслийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын М.Ганхүлэг, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Мөнхнасан, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх Б.Батбаатар, Д.Гантулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, М.Бадамсүрэн, Ж.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Б.Бейсен: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 5
Бүгд: 16
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 57 минут үргэлжилж, ирвэл зохих 24 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 21 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
11 цаг 24 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 54,2 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Хуралдааны ирцийг танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Агваанлуvsангийн Ундраа гишүүн ирсэн байна.

Хэлэлцэх асуудалд оръё. Хэлэлцэх асуудал танилцуулна. 2 асуудал хэлэлцэнэ. 1 дэх асуудал дотроо 4 зүйлтэй зүйл бүрээр тусгаж хэлэлцэнэ. 1 дүгээр Асуудал агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт ЗГ-аас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ бид Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ. 2 дахь асуудал Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн байхгүй байна.

Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэх асуудалдаа оръё. 1.Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг ирчихсэн юм уу бүгд? Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ц.Уртнасан ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ц.Уранчимэг Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, З.Батбаяр Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, НЗДТГ-аас Х.Нямбаатар Нийслэлийн

Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч одоо орж ирж байгаа байх. М.Үнэнбат Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Д.Мөнхбат Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Материалаа өгсөн юм уу? 1 дүгээр зүйлтэй холбоотой саналтай гишүүн байхгүй байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Уянга гишүүнээр тасаллаа. Ганхүлэг гишүүний асуулт асууя.

М.Ганхүлэг: Ажлын хэсгийн гишүүдээс тодруулъя. Манай Байнгын хороо ерөнхийдөө голчлоод утааны эсрэг сонсголыг зохион байгуулсан. Сонсголын хүрээнд тухайн үед яригдаж байсан хэд хэдэн асуудлуудыг би нэмээд тодруулчихъя гэж бодож байна. Хамгийн эхэнд нь өнгөрсөн жил бид бүхэн эрчим хүчнийхээ үнийг нэмэгдүүлсэн. Үүнтэй холбогдолтойгоор яндангаа буулгасан айлууд, өөрсдөө эрчим хүчээ цахилгаанаар шийдсэн айлуудын хувьд нэлээн хүндрэлтэй байдлууд үүссэн. Тэгэхээр яах вэ бидний төлөвлөж байгаа тодорхой ажлууд нэлээн урт хугацаандаа би үр дүнгээ өгөх болов уу гэж бодож байна. Яг одоо энэ шууд энэ өвөл гэхэд цахилгаанаар эрчим хүчээ хангаж байгаа хүмүүсийн хувьд ямар зохицуулалтуудыг хийж байгаа вэ? Түүнтэй холбогдолтой энэхүү хуульд орж байгаа тийм өөрчлөлтүүд байна уу?

Мөн дээрээс нь энэ 3 дугаар агуулга дээр энэ амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой гэсэн энэ агуулгыг илүү тодруулж асууя. Яагаад энийг үндсэндээ оруулж ирж хасахаар оруулж ирж байгаа вэ? Ямар тооцоолол юмнууд байгаа вэ гэдэг дээр нэмэлт тодруулга авъя.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

М.Үнэнбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Гишүүний асуултад хариулъя.

Б.Бейсен: Албан тушаал танилцуулж байгаарай.

М.Үнэнбат: НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газар Үнэнбат. Гишүүний асуултад хариулъя. Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах зохицуулалттай холбоотой асуултын талаар танилцуулаад, тэгээд нэмээд энэ өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой энэ цахилгаанаар халаах болон хийн халаалтад шилжих, мөн энэ агаарын бохирдлын эсрэг авч хийж байгаа арга хэмжээний талаар манай нийслэлийн Мөнхбаатар дарга хариулна.

1 дүгээрт нь Агаарын хуульд бид бүхэн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхийг хийн түлшээр хангах, үүнтэй холбоотой гээд тодорхой хэмжээний урамшуулал олгох журмыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурал батлах энэ зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаж орж ирж байгаа. Үүний гол зорилго юу байна вэ гэхээр энэ нийслэлийн агаар орчны бохирдолтой холбоотойгоор нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүст хийн түлшээр хангах, тэр тусмаа энэ жилийн тухайд 50 мянган айлыг хийн түлшээр хангана гэсэн ийм зорилт тавьж ЗГ ажиллаж байгаа. Энэ хүрээнд нь ЗГ-ын тогтоол гарсан. Хийн түлш яг өнөөдрийн байдлаар хийн түлшээр хангахад харьцангуй зардлын тухайд тодорхой хэмжээний өндөр ийм зардал гардаг. Үүнтэй холбоотойгоор тодорхой хэмжээний урамшууллыг байдаг юм уу, тэр олгож байгаа тэр гарч байгаа зардлаас нь хөнгөлөлт үзүүлэх байдлаар энэ асуудлыг шийдвэрлэх бололцоотой гэж ЗГ-ын хуралдаан дээр ярилцаж, энэ хүрээндээ энэ журам батлах эрхийг НИТХ-д олгохоор ийм зохицуулалтыг тусгаж байгаа. Үүний цаад зорилго юу байна вэ гэхээр Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу аливаа захиргааны хэмжээний нийтээр дагах захиргааны хэмжээний акт батлан гаргахад заавал ч үгүй эрх олгогдож байж энэ хүрээндээ тухайн захиргааны хэмжээний актыг баталдаг. Ингэж байж энэ эрх олгогдсон заалтын хүрээнд захиргааны хэмжээний актыг баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, энэ хүчин төгөлдөр болдог ийм хуулийн зохицуулалттай. Энэ хүрээнд оруулж ирж байгаа.

2 дугаарт нь амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн гэр, байшингийн дулаалга, сайжруулсан зуух, агаарын бохиргүй шахмал түлш, хагас кокс болон шингэрүүлсэн түлшээр хангах асуудлыг шийдвэрлэхэд энэ зохицуулалтын амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой гэдгийг хасахаар ийм зохицуулалт орж ирж байгаа. 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаа, баталсан амьжиргааны баталгаажих доогуур түвшнээс доогуур орлоготой бүсээр нь тогтоосон. Энэ хүрээндээ Улаанбаатарт 495400 төгрөг байна гэж ингэж заасан байгаа. Тэгэхээр 495400 өнөөдрийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ доод 780 мянга байгаа. Энэ хоорондын орлоготой маш олон иргэд байдаг. Тэгэхээр энэ амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой буюу 495 мянгаас доош орлоготой хүмүүст тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх бололцоо байгаа хэдий ч энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хоорондын энэ 300 мянган төгрөгийн хоорондын зөрөөтэй ийм маш олон өрхүүд энэ.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

М.Үнэнбат: Тэгэхээр дүүрэг, хороон гарч байгаа судалгааны хүрээнд энэ амьжиргааны баталгаажих доод түвшнээс дээгүүр, тэгсэн мөртөө хөдөлмөрийн хөлсний доод түвшнээс доогуур орлоготой ийм иргэд байгаа учраас энэ хуулийн заалтаас шалтгаалаад тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлэх бололцоогүй болчихоод байгаа учраас энэ зохицуулалтыг нь аваад, тэгэхдээ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас журам батлахдаа мэдээж орлого орлогынх нь байдлыг харгалзан энэ дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдэж явах энэ зохицуулалтыг тусгахаар хуулийн төслийг оруулж ирсэн байгаа. Хийн түлш болон бусад энэ өвөлжилтийн бэлтгэлтэй холбоотой асуудлыг хуралдаан даргалагч зөвшөөрвөл манай Нийслэлийн Байгаль орчны газар Мөнхбаатар дарга хариулна.

Б.Бейсен: 2 номер хариулъя.

Д.Мөнхбаатар: Сайн байцгаана уу, Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дарга Мөнхбаатар. Эрчим хүчний үнэ өнгөрсөн жил нэмэгдсэн. Улаанбаатар хот, нийслэл, дүүргийн нийт 9 мянга гаруй албан хаагч 1 дүгээр

сарын 18, 19-ний өдөр нийт Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг нийт тооллого тоолсон байгаа. Энэ тооллогоор нийт 172 мянга гаруй гэр хорооллын айл өрх бүртгэгдсэн. Үүнээсээ яг тухайн үед 11 мянга гаруй айл өрх цахилгаан халаагууртай байсан. Цахилгааны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор бидний хийсэн судалгаагаар ойролцоогоор 1800 орчим айл өрх буцаагаад яндан, цахилгаан халаагуураасаа хатуу түлшний хэрэглээ рүү шилжсэн гэсэн ийм судалгаа гарсан байгаа. Энэ амьжиргааны доод түвшний асуудлыг бид бүгд ярьж байгаа гол ач холбогдол нь юу вэ гэхлээр бид утааг янданг л бууруулъя гэдэг яг үндсэн зорилго тавьж байгаа. Ер нь маш ойлгомжтой байдлаар хэлэхэд нийт.../минут дуусав/

Б.Бейсен: 2 номер гүйцээж хариулъя.

Д.Мөнхбаатар: Нийт Улаанбаатар хотод 9 мянга гаруй яг амьжиргааны доод түвшинд хүрэхгүй ийм айл өрх байна гэсэн ийм судалгаа байдаг. Мөн бид яг үндсэн зорилго энэ айл өрхүүд маань өөрсдөө сайн дураараа хий болон цахилгаан халаагуур луу шилжээд, дээрээс нь өөрсдөө өрх гэрээ дулаалсан тохиолдолд ийм урамшуулалд хамруулъя гэдэг ийм нөхцөлийг оруулж ирж тавихыг зорьж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор яг амьжиргааны доод түвшин гэхээсээ илүү айл өрх маань яндангаа буулгасан, хатуу түлшний хэрэглээнээс татгалзсан, өрх гэрээ дулаалсан тохиолдолд энэ урамшууллын системд хамруулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй явж байгаа.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: 1800 айл энэ жил дахиад хэд болж нэмэгдэхийг бол мэдэхгүй. Тэгэхээр үүнтэй холбогдолтой ямар арга хэмжээг илүү авах вэ гэдэг тийм тодорхой асуулт байгаа. Өөрчлөлт яаж орж байгаа вэ хуулийн төсөлд тусгагдаж байгаа зүйлүүд байна уу? Эрчим хүчний үнэ нэмэгдсэн энэ байгаа байдал яг тодорхой гэр хорооллын энэ зуухаа сольж байгаа иргэдэд арай өөр байдлаар хандах ийм саналыг та бүхэн Эрчим хүчний яам болон харьяа газруудад тавиад, тодорхой үр дүнгүүд гарч байгаа зүйлүүд байна уу, эд нарыгаа ер нь хамгаалах юм уу, эсхүл 1800 бол ингээд буцаад зуух руугаа шилжсэн гэдэг энэ тоогоо хэдүүлээ ингээд нэмэгдүүлээд яриад байх юм уу гэдэг ийм асуулт байгаа юм. Тэгэхээр цаашдаа яг ерөнхийдөө яг эрчим хүчээр асуудлаа шийдэж байгаа айлуудаа яаж шийдэх юм бэ, энэ чиглэлийнхээ ажлыг яах вэ хийсэн тохиолдолд урамшуулна гэж байх шиг байна. Тэгэхдээ ер нь нэмэгдсэн нөхцөл байдал нь үндсэндээ 2-оос 3 дахин өндөр төлбөр төлөөд эхэлсэн учраас л эдгээр хүмүүс чинь шилжээд байна л даа. Тэгэхээр энийг хязгаарлах арга хэмжээ юмнуудыг ер нь авах уу, үгүй юү гэдгийг л тодруулаад байна л даа.

Б.Бейсен: 2 номер хариулъя.

Д.Мөнхбаатар: Эрчим хүчний үнийн нэмэлтийн асуудлаар энд бол Эрчим хүчний зохицуулах хороо тодорхой гарц гаргалгаа шийдэл ярих байх. Нийслэлийн зүгээс яг бид ахиж энэ янданг нэмэхгүй байх, аль болох иргэдийг цахилгаан буюу эко ийм хийн, бохирдол агаарын бохирдуулагч бага ялгаруулахын тулд ийм үнийн урамшууллыг л эхний ээлждээ өгье. Тэгэхдээ үүнийхээ тулд та бүгд маань хатуу түлшнээс татгалзсан байх ёстой, айл гэр өрх маань гэрээ сайн дулаалсан байх ёстой гэдэг рүү чиглэж байна. Мөн ахиад эрчим хүчний хэмнэлт үүсгэх зорилгоор нийслэлийн зүгээс айл гэрийг хэрхэн яаж дулаалах вэ, дулаасныг, дулааснаар

хэчнээн төгрөг эрчим хүчний хэмнэлт үүсэх вэ гэдэг талаар сургалт ийм зүйлүүдийг явуулахаар төлөвлөөд ажиллаж байна.

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Асуулт авчихсан, тийм болохоор өнжье дөө.

Б.Бейсен: Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Хуулийн төслийн 3 дугаар заалт дээр тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд тодорхой урамшууллын асуудал ярьж байгаа юм байна. Амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой гэдэг нэлээн олон үзүүлэлтүүдийн нийлбэрээр гарч ирдэг. Та хэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай ярих гэж байна. Тэр бол орлогоос үл хамаараад хөдөлмөр эрхэлж байгаа дан дамаа хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол та тэр хүнд тэдэн төгрөгөөс доош цалин өгч болохгүй гэдэг ийм л зохицуулалт байхгүй юу. Тэгэхээр энэ 2 үзүүлэлтийг хооронд нь нийцүүлж авч үзнэ гэж байж болох юм уу, үгүй юм уу? Энийгээ их л сайн бодоорой гэдгийг хэлмээр байна. Энэ дээр ер нь ямар бодол тооцоололтой ийм зүйл орчих вэ гэдэг асуудал.

2 дахь зүйл хуулиар тусгайлан зохицуулаагүй дээд түвшний байгууллагын эрх хэмжээнд оччихоогүй асуудлыг энэ нутгийн удирдлагын байгууллага, тэр тусмаа нутгийн өөрөө удирдах байгууллага бие даан шийдвэрлэх эрх нь Үндсэн хуулийн 62-оор байгаа юм. Тийм заалт бий. Тийм учраас өөрсдийнхөө шийдэж болмоор юмнуудыг дутуу боловсруулалттай эрх зүйн зохицуулалт хийчихвэл өөрсдийнхөө үйл ажиллагааг чөдөрлөчихнө шүү. Энэ тал дээр ямар тооцоолол байгаад байгаа юм бэ? Үүнийг нэг асуумаар байх юм.

Өвөл болдгоороо болно, хэдүүлээ их л юм ярьцгааж байгаа, их л сонсгол сонсоцгоож байгаа. Тэгээд эцэстээ ямар түлш түлэхээ шийдэл гаргаагүй байгаад байгаа шүү дээ. Наадах чинь өвөлжилтийн бэлтгэлд чинь нэлээн төвөгшил үүсгэнэ дээ. Ямар шийдтэй байна вэ гэдэг нэг ийм асуудал.

2 дугаарт саяын эрчим хүчний салбар дээр бий болсон аваарын нөхцөл байдал цахилгааны эх үүсвэр тал дээр жоохон хязгаарлалт үүсэж магадгүй болчхоод байгаа. Тийм учраас айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр дулааныхаа асуудлыг шийддэг шийдлийг их сайн Эрчим хүчний яамтайгаа тооцооллоо хийж, тов тодорхой болгож байж өвөлжилтийн бэлтгэл ажлынхаа төлөвлөлт юманд оруулахгүй бол хэдүүлээ жоохон эргэлзээтэй юм билээ. Харин өнөө нэг 10 мянган айл сэргээгдэх эрчим хүч өөр дээрээ тавьж байгаа, дэлгэц тавьж байгаад цахилгаан, дулаанаа шийдчих ийм төсөл хэрэгжүүлж эхэлнэ гээд ингээд яригдаад байсан. Энэ маань ер нь хэрэгжилт, эхлэл нь ер нь ямархуу түвшиндээ байна вэ? Үүнийг нэг тодруулж асуумаар байгаад байх юм.

Б.Бейсен: 5 номер Нийслэлийн Засаг дарга, Улаанбаатарын захирагч Нямбаатар ирсэн байна, хариулъя, 5 номер.

Х.Нямбаатар: Би Батжаргал гишүүний асуултад хариулъя. Энэ Агаарын тухай 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтын амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой гэдгийг хасахгүй болохоор бид агаарын бүсчлэл тогтоогоод, нөгөө агаарын бүсчлэлтэй хийн түлш, цахилгаан зуух нэвтрүүлэх гэхээр энэ

шаардлагыг хангаагүй байна гээд энэнээс дээгүүр орлоготой хүмүүст нөгөө хөнгөлөлт урамшуулал үзүүлэх нь ингээд хуулиар хязгаарлагдаад байгаа юм. Тэгэхээр энийг авч хаяж байж, бид агаарын бохирдолтой тэмцэхийн тулд жишээлбэл Гандан орчим гэдэг юм уу, Эх нялхсын орчим гэдэг юм уу, Улсын бүртгэлийн орчинд бид хатуу түлш хэрэглүүлэхгүй гээд бүсчлэл тогтоочоод, тэндээ тодорхой урамшууллуудыг өгч байж, энэ бүсчлэлийг хэрэгжүүлэх шаардлага үүсээд байдаг. Гэтэл Агаарын тухай хуульд урамшуулал олгохын тулд заавал амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой байж л тэр урамшууллыг авна гэдэг нь өөрөө амьдрал дээр нийцэхгүй байгаа учраас энийг ингээд хасаж байгаа гэсэн нэг дэх хариултыг өгөх гэсэн юм.

2 дугаарт Батжаргал гишүүн ер нь энэ өвөл юу түлэхээ хэдүүлээ яг шийдэж байна уу? Өвөл болох гээд байна. Одоо яг 9 сарын 15-наас эхлээд бид нүүрс болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах чиглэлээр ажлууд хийгдэж эхэлнэ. Одоогоор Эрдэнэс Тавантолгой компанийн агуулахад 40 мянган тонн мидлинг байна. Түүнээс бараг илүү шахагдсан шахааны чанарын шаардлага хангахгүй барьцалдуулагч байна. Энэ утгаараа бид 4 сарын 15-наас эхлээд Энержи Ресурс компанитай байгуулсан мидлинг үнэ төлбөргүй нийлүүлэх гэрээгээ Энержи Ресурс компани дуусгавар болгосон. Орлуулах бүтээгдэхүүнийг нь бид хайж, Эрдэнэс Тавантолгойн баяжуулах үйлдвэрийн тэг давхаргын нүүрсийг сая үндсэндээ 2 сар гаруй барьцалдуулагч нартай хольж, шахмал түлш гаргах ийм үйлдвэрлэлийн туршилт хийсэн. Харамсалтай нь амжилтгүй болсон. Эрдэмтдийн зөвлөл, Химийн хүрээлэн, Үндэсний хороо бүхэлдээ хагас кокс нүүрсийг түлж байж, энэ өвөл харьцангуй агаарын бохирдлыг 50 хувиар бууруулна, угаарталтаас урьдчилан сэргийлэх ийм боломжтой гэдэг дүгнэлтүүд гаргасан. Энэ дагуу 5 дугаар сарын 16-ны өдөр Үндэсний хорооны шийдвэрийн дагуу Эрдэнэс Тавантолгой, биш ээ сайжруулсан түлшний үйлдвэр Тавантолгой сайжруулсан түлшний үйлдвэр өөрийн компанийн хөрөнгөөрөө 300 мянган тонн хагас кокс буюу жигнэсэн давирхайг нь салгасан, хүхрийг нь салгасан түүгээр хийсэн түүхий эдээр суурилсан асаагчтай ийм түлшний олон улсын нээлттэй тендер зарласан.

Б.Бейсен: 5 номер гүйцээж яриулъя.

Х.Нямбаатар: Тендер 7 дугаар сарын 18-ны өдөр нээгдэнэ. Ингээд худалдан авах хуулийн процесс дуусаад, энэний дараа бид нийлүүлэлтээ 8 дугаар сарын 25-наас эхэлж бид ачилтаа наашаа хийнэ гэж байгаа. Яагаад гэхээр цаг агаар бороотой үед задгай тээвэр явдаг учраас бороо багассан үед бид 8 сарын сүүл, 9 сар, 10 сар, 11 сард бид 300 мянган тонн нүүрсээ татна, 40 мянган тонн мидлингээ дуусгана 340, агуулахын үлдэгдэл 10 байгаа, дахиад бид энэ өвлийн градус температурыг харгалзаж үзэж байгаад 50 мянгаас 100 мянган тонн нүүрсийг нэмж 2 дугаар сард авах уу, үгүй юү гэдгээ эцэслэж шийдэх ийм төлөвлөгөөтэй явж байгаа. Саяхан 6 дугаар сарын 4-ний байна уу, 5-ны өдөр гарсан Улсын Их Хурлын 53 дугаар тогтоолтой манай худалдан авах ажиллагааны зөрчил.../минут дуусав/

Б.Бейсен: 5 номер гүйцээж хариулъя.

Х.Нямбаатар: Чанар стандартыг Шинжлэх ухааны академи, химийн хүрээлэн холбогдох мэргэжлийн байгууллагууд техникийн тодорхойлолтыг гаргаж өгсөн. Монгол Улсад хүлцэх хэмжээний тэр хүхрийн хэмжээ бусад давирхай болон химийн хортой бүтээгдэхүүний хамгийн байж болох хүлцэх хэмжээгээр бид

түлшнийхээ техникийн тодорхойлолтыг гаргасан байгаа гэдгийг хэлье. Цахилгаан дээр Бөөрөлжүүтийн 150мвт 12 сарын 5-ны өдөр орно. Эрчим хүчний хязгаарлалт хийхгүйгээр энэ өвөл орох боломжтой гэж үзэж байгаа. Хүннү дээр 90мвт-ын батарей станцын төр, хувийн хэвшлийн түншлэлийн тендер зарлачихсан явж байгаа. Хог шатаах үйлдвэрийн 34мвт-ын тендерийг 8 сарын 1 гэхэд эцэслэн шалгаруулна. 5 дугаар цахилгаан станцын урьдчилсан шалгаруулалтыг өчигдөр орой бид эхний сонгон шалгаруулалтаа хийсэн, одоо 2 дугаар шатын сонгон шалгаруулалт руугаа орж байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Хэдүүлээ Улаанбаатар хотын гэр хорооллыг барилгажуулах, инженерийн шугам сүлжээлүүлэх том бодлого явж байгаа. Тэрнийгээ бид тэргүүлэх зорилтоо болгож хэрэгжүүлэх ёстой юм. Тэгэхээр энэ завсрын хугацаанд аль болохоор юу гэдэг юм бэ дээ зардал бууруулах хэлбэртэй байж болдог бүхий л арга хэмжээнүүдийг нь авч хэрэгжүүлмээр байгаа юм. Зуух ч байж болж байна, түлш нь ч байж болж байна, цахилгаан нь ч байж болж байна, хий нь ч байж болж байна. Би наад тооцоонуудыг чинь 2, 3 удаа сонсож, дүгнэлт хийж байсан мэднэ. Одоо бидний түлээд байгаа түлш чинь бараг 600 орчим мянгаар гараад бид хэд 150-аар зараад байгаа улс шүү дээ. Хагас коксжуулсан руу шилжье гэвэл 1 сая 200 хамгийн багадаа гарахаар ийм тооцоолол тухайн үед яригдаж байсан бүр тооцоо юмнуудыг нь үзэж байсан. Тэгэхээр зэрэг энэ нэг хоорондын борлуулалтын үнэ, үйлдвэрлэлийн үнэ 2-ын зөрөө дээрээс хэдүүлээ ачаалал үүрээд байгаа юмнуудаа аль болохоор ганц нэг жил зөв бодоод, тэгээд харин тэр дэд төвүүдээ байгуулах, эх үүсвэрүүдээ нэмэгдүүлэх юманд тодорхой жоохон гарч ирж байгаа эх үүсвэрийнхээ тодорхой хэсгийг чиглүүлээд явчихвал ер нь яг нарийндаа явж, явж 150мвт-ын станц барья гэвэл бараг энэ Улаанбаатар хотын утаа бууруулах чиглэл дээр хийгээд байгаа бидний юмны 2 жилийн өртөгтэй дүйх хэмжээний л юм байгаад байгаа шүү дээ энэ чинь ний нуугүй үнэнийг хэлэхэд. Энэ рүү л хэдүүлээ гарвал. Тэгээд би та бүгдийг ажил нуруун дээрээ үүрээд, толгойгоороо хариуцаад явж байгаа улсуудын зовлонг мэднэ. Энэ хуулийг дэмжээд батлаад өгье. Та хэд маань тэгээд энэ Улаанбаатарын ард түмнийг нэг эрүүл, аюулгүй орчинд амьдрах юман дээр нь томоохон алхам хийсэн, алсын том бодлогоо тууштай барьж хөдөлгөж чадсан ийм ажлуудаа зоригтойнхон шиг явуулаарай.

Б.Бейсен: Батжаргал гишүүн үг хэллээ. 5 дугаар микрофон Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Батжаргал даргаа, та бид яг нөгөө орон нутагт ажиллаж байсан учраас Үндсэн хуулийн тэр 62-оор иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэм хэмжээ тогтоосон акт журмууд гаргахаар ХЗДХЯ-ны захиргааны акт бүртгэдэг алба ерөөсөө бүртгэж авахгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл салбарын хуульд яг энэ төрлийн зохицуулалт ороогүй байна гэдэг утгаараа захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэж авахгүй нэг ийм жишиг прецедент тогтож өгөхгүй байгаа гэдгийг л хэдүүлээ ойлгомоор байна. Тийм учраас бид.../үг тасрав/

Б.Бейсен: 3 дугаар зүйлийг хэлэлцэж дууслаа. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж дууслаа.

2 дугаар асуудалд оръё. Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулъя. Ажлын хэсэг хэвээрээ. Төслийг мөн зүйл бүрээр хэлэлцэнэ. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу, нэрс өгнө үү? Ганхүлэг гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүний асуулт асууна. Ганхүлэг гишүүний асуулт асууна, ирцээрээ орж байгаа юм байна.

М.Ганхүлэг: Усны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдолтой усны ажлын хэсгийг манай Уянга гишүүн ахлаад бид нэлээн ажилласан. Хэд хэдэн зүйл тодруулъя гэж бодож байна. Үндсэндээ Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дээр усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно гэсэн энэ агуулгын хүрээнд тодорхой өөрчлөлт нь орж ирж байгаа юм байна. Тэгэхээр нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад гэж нэмсүгэй гэдэг энэ агуулгад хувийн хэвшлийн бүтээн байгуулалтын ажлууд орох уу? Хувийн хэвшлийнхэн. Үндсэндээ нийслэлийн явуулж байгаа том төслүүдийг хэрэгжүүлэхэд тодорхой саад учирч байгааг ойлгож байна. Гэхдээ энэ хуулийн тодорхой үндэслэлийг бариад, бас яг энэ бүсүүд дээр хувийн хэвшлүүд давхар бүтээн байгуулалтууд хийгээд ингээд эхлэх, түүн дээр хяналт шалгалт юмнууд явуулахад хүндрэл учрах ийм нөхцөлүүд үүсэх үү гэдэг ийм асуудлууд байгаа. Үүнтэй холбогдуулаад өмнө нь тодорхой энэ агуулгыг зөрчсөн бүтээн байгуулалтуудыг хувийн хэвшлүүд хийчихсэн байгаа. Бид нураана, нураахгүй, болино, болихгүй гээд түүн дээр та тодорхой байр сууриа илэрхийлээд ажиллаж байгаа. Тэгэхээр тэр төслүүд дээр буцаад давуу байдлууд бий болох энэ тэр гэдэг ийм агуулгууд орж ирэх үндэслэл байх уу гэдгийг тодруулъя.

Б.Бейсен: 5 номер Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Энэ усны онцгой хамгаалалтын бүсэд ерөөсөө бид одоо болтол хууль зөрчөөд төр нь ч тэр, хувь нь ч тэр бүтээн байгуулалт хийгээд байгаа. Өөрөөр хэлбэл Байгал орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А230/127 дугаар хамтарсан тушаалаар усны онцгой хамгаалалтын бүсэд барилга байгууламж барих энэ зөвшөөрлийг олгоод яваад байгаа. Гэтэл Усны тухай хуульдаа усны онцгой хамгаалалтын бүсэд ерөөсөө барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барихыг хориглосон зохицуулалттай. Тэгэхээр бид өнөөдөр жишээлбэл манай үнэлгээний хороо яг одоо биднийг энд хуралдаж байх үед хуралдаж байна. Нөгөө Туулын хурдны зам гээд тендерийн сонгон шалгаруулалт хийгдэж байна. Туулын хурдны зам яг усны хамгаалалтын бүс буюу Туул голын хойд эргээр нэг талдаа 33км, 2 талдаа дэлгэмэл уртаараа энэ 66км ийм бүтээн байгуулалтын ажил хийгдэнэ.

Тийм учраас бид энэ бүтээн байгуулалтын ажлаа энэ Усны тухай хуультай нийцүүлж, усны онцгой хамгаалалтын бүсэд нийтийн зориулалттай инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн барилга байгууламж барихыг зөвшөөрнө гэсэн ийм агуулгаар энэ өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Ганхүлэг гишүүний асууж байгаачлан тэр хувийн хэвшлийн бүтээн байгуулалт барилга байгууламжтай холбоотой зүйлийг энд хамааруулж ойлгохгүй гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл та бидний өнөөдрийн энэ Байнгын хорооны хуралдаан дээр хэлэлцэж байгаа хэлэлцүүлгийн протокол нь өөрөө энэ хуулийн хувийн хэрэгт үлдэх учраас энд ямар нэгэн хувийн секторын барилга, бүтээн байгуулалттай холбоотой бүтээн байгуулалт орохгүй. Зөвхөн нийтийн зориулалттай инженерийн шугам сүлжээ, дэд

бүтцийн бүтээн байгуулалтад орно. Харамсалтай нь өнөөдөр Туул гол, Дунд голын эрэг дагуу усны хамгаалалтын тэр бүс, онцгой хамгаалалтын бүсэд маш их хэмжээний барилга байгууламжууд баригдчихсан байгаа. Сүүлд НИТХ-аар бид энэ хэмжээ дамжааг нь холдуулах гаргах ийм зохицуулалтыг нийслэлийн иргэдийн Хурлаар баталсан гэдгийг хэлье. Тэгэхээр энэ бидний өнөөдрийн энэ хэлэлцүүлгийн протокол өөрөө энэ хуулийн хувийн хэрэгт үлдэж байгаа.

Б.Бейсен: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Гэхдээ хэдүүлээ тодруулмаар юмнууд байгаа юм байна лээ. Яг хийгдэж байгаа бүтээн байгуулалттайгаа холбоотой барилга байгууламжийн л асуудал байх ёстой юм байна лээ. Энд барилга байгууламж гээд нийтлэг хэлээр хэлчхээд байгаа учраас гишүүд яг тэгж ойлгогдоод болж өгөхгүй байгаа. Тэгээд яах вэ ер нь энэ сав газрын онцгой хамгаалалтын бүс дотор юм хийх гэж байгаа бол байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгээд, ямарваа нэгэн нөлөөлөлгүй гэсэн дүгнэлт гарлаа бол түүн дээр нь тулгуурлаж энэ дэд бүтцийн хийгээд, дэд бүтэц өөрт нь амин сүнс болсон барилга байгууламжийн асуудал хийгдэж болохоор л энэ хуулийн заалт яг өөрөө тэгж томъёологдох ёстой. Би зориуд энэ тэмдэглэл дотроо үлдчихье гэж бодож байна. Болж өгвөл манай төсөл өргөн баригч ийм байдлаар томъёолоод өнөөдөр анхны хэлэлцүүлэг дээр нэг гишүүнээр санал гаргуулаад хураалгачихвал хэдүүлээ нийгэмд очиход илүү, дутуу юм яриад сэвүүлээд байхгүй амар юм даа гэж бодоод байна шүү дээ.

Б.Бейсен: 5 номер Нямбаатар дарга хариулъя.

Х.Нямбаатар: Тэгээд өнөөдрийн чуулган, Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдээс нийтийн зориулалттай гээд зарчмын зөрүүтэй санал гаргачихвал бид энийг дэмжээд явчихна. Тийм Эрдэнэбүрэн сайд өөрөө энэ хуулийн төслийг үзэл баримтлалыг баталж, боловсруулчихсан хүний хувьд нийтийн зориулалттай гэдэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргаад ингээд явчихвал өөр ямар нэгэн маргаангүй болчихно 1 дүгээрт.

2 дугаарт Батжаргал гишүүнээ энэ хийгдэх бүх ажлууд ТЭЗҮ-тэй, ТЭЗҮ нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэж, Байгаль орчны яамаар бүгд батлагдсан гэдгийг танд хэлье. Туулын хурдны зам, тойрог хурдны зам аль, аль нь Байгаль орчны яамаар нарийвчилсан үнэлгээнүүд нь батлагдсан өнөө өглөө. Тэгэхээр Эрдэнэбүрэн сайд саяын томъёоллоор нийтийн зориулалттай гээд горимын санал гаргаад.

Б.Бейсен: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Яг сая 22.2.1-ийг үргэлжлүүлээд энэ дээр нэг тийм зарчмын зөрүүтэй санал бэлдэж байсан юм. Тэгэхдээ сая Нямбаатар даргын хариултаас нэг арай өөр болохоор юм шиг. Одоо гишүүдэд тараагдаж өгсөн байгаа хувилбар нь 22.2.1 нь онцгой хамгаалалтын бүсэд Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, барилга байгууламжаас бусад гээд явчихсан байгаа. Тэгээд нөгөө хуульчидтай суугаад ярихаар таслалын өмнөх, хойд тал нь гээд 2 өөр агуулга яригдаад байдаг учраас түрүүн Батжаргал гишүүний хэлж байсантай адилхан Ганхүлэг гишүүн ч хэлэх шиг болсон. Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц гэдэг нь ингээд дэд бүтэц юм байна, барилга

байгууламж гэдэг нь нэг хувийн хэвшлийнхэнд хамаарчихаар юм шиг уншигдах вий дээ гэж бодоод, Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц бүхий таслалын оронд бүхий гэдэг үг аваад барилга байгууламж гээд явчихвал яасан юм бэ гэсэн саналыг гаргачихсан байсан юм, биччихсэн байсан юм. Гэхдээ тэр нөгөө хурдны замтай холбоотой өөр төрлийн барилга байгууламж заавал инженерийн дэд бүтэц биш, барилга байгууламж байхаар байгаа учраас саналын томъёоллоо арай өөрчлөх хэрэгтэй юм шиг байна. Тэгэхээр ингээд явчихвал болохоор байна уу, манай ажлын хэсгийнхэн хараад хэлээд өгөөч? Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад гээд өөрчлөөд явчихвал? Тэгвэл тэгээд саналаа өгчихөд болохоор байна уу энэ асуулт?

Б.Бейсен: 5 номер хариулъя. Та саналаа бичиж өг. Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Сая харин бид энэ гишүүд ярьж байна. Яг үнэндээ энэ хуулийн үзэл санаа угаасаа яг Улаанбаатар хотод зориулагдаж болохгүй юм байгаа юм гэдэг дээр санаа хэлэх гэсэн юм. Төв суурин газрууд энэ гол мөрний сав газруудад бүтээн байгуулалт, барилга байгууламжууд баригдахад энэ байгаль экологийн асуудлыг нэг талаасаа яах юм бэ хэдүүлээ? Бүтээн байгуулалт нэрийн доор байгаль экологидоо бид ингээд яаж хандах гээд байгаа юм бэ гэдэг энэ санааг өнөөдрөөс энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамныхан байгаа дээр тодруулмаар байгаа юм. Эсвэл сая тэр Батжаргал даргын хэлснээр байгаль орчны үнэлгээ гарсны дараа баригдана гэх юм уу? Ингэвэл хугацаа алдах бүтээн байгуулалтын манай улирлын чанартай асуудлууд өөрөө ямар хугацаанд явагддаг билээ энэ нь юу болох вэ? Энийг нэг аль аль талаас нь уялдуулж хэдүүлээ хийхгүй бол яг нэг талаа харчихвал болохгүй болов уу гэж ингэж бодогдоод тэгээд энэ асуултыг асуумаар санагдсан юм.

Б.Бейсен: Нямбаатар дарга хариулъя 5 номер. 5 номерын микрофон.

Х.Нямбаатар: Би Мөнхбат гишүүний асуултад хариулъя. Мөнхбат гишүүн бид Туулын зам ч тэр, тойрог хурдны зам ч тэр банкны шаардлага хангасан ТЭЗҮ буюу банк able ТЭЗҮ боловсруулах ажлыг энэ жил гаруйн хугацаанд хийсэн. Энэ банк able ТЭЗҮ-д тавигддаг 1 хамгийн том шаардлага нь олон улсын нэр хүнд бүхий байгууллагаар байгаль орчны нарийвчилсан үнэлгээг хийлгэж байж энэ шаардлага өөрөө дүйж очдог. Тэр утгаараа бид Туулын зам дээр ч тэр, тойрог зам дээр банкны шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулсан, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн. Өнөө өглөө Байгаль орчны яаман дээр жишээлбэл тойрог 1 дүгээр хурдны замын байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Байгаль орчны яам баталж өгсөн. Тийм учраас бид байгаль орчны нарийвчилсан үнэлгээгүй бүтээн байгуулалтын ажлыг гол мөрний сав газар огт хийхгүй. Энийгээ заавал батлагдаж байж энэ нь тэгэхдээ олон улсад нэр хүнд бүхий байгууллагуудаар байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээ хийлгэж дуусгасан гэдгийг хэлье. Тэгж байж бүтээн байгуулалтын ажил эхэлж байгаа.

Б.Бейсен: Асуулт асууж дууслаа. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний асуулт асууя. Хариулт 3 номер, Бат-Эрдэнэ гишүүн түр хүлээж байгаарай. 3 номер хариулъя.

3.Батбаяр: Усны газар Батбаяр. Манай эрхэм гишүүдийн анхаарал манай Монгол Улсад ус, тэр дундаа голын сав газар дээр голыг хамгаалах систем маань өөрөө хамгаалалтын бүсээр дамжиж явагддаг. Систем маань 2 янзын, хамгаалалтын систем нь 2 янзын зүйл байдаг. Нэгдүгээрх нь усан сан бүхий газар буюу голын эргээс ямар зайд ямар дэглэм барих вэ гэж. Одоо бидний ярьж зүйл бол онцгой дэглэм буюу голын эргээс 50 метрийн зайтай үйл ажиллагаа явж байгаа. Энгийн хамгаалалтын бүс 250 байгаа. Дараагийн хамгаалалтын бүс маань эрүүл ахуйн хамгаалалтын бүс буюу ундны усны эх үүсвэрээс тодорхой зайд хамгаалах тухай асуудал байдаг. Тэгэхээр энэ бүтээн байгуулалтын асуудлууд маань мэдээж явах ёстой. Гэхдээ голынхоо хамгаалалтын бүсийн системээ бид эвдэх юм уу, систем рүү маань өөр зүйл орох үүд хаалга нээчих вий гэж болгоомжилж байгаа учраас бидний зүгээс урьд нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ч ярьж байсан Усны тухай хуульдаа.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхбат гишүүн тодруулъя.

Ц.Мөнхбат: Батбаяр даргаас тодруулъя тэгвэл. Энэ сая Нямбаатар дарга ярилаа шүү дээ олон улсын нэр хүндтэй байгууллагаар байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийж байж бид энэ бүтээн байгуулалтын асуудлуудыг явуулна гээд. Гэтэл саяын таны ярьж байгаагаар энэ 50 метрийн дотор орохлоороо зэрэг тэр эко систем энэ тэр эвдэгдээд, үр дагавар бий болж магадгүй юм шиг ийм хэлчихлээ. Тэгэхээр зэрэг тэр олон улсын байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гэдэг чинь тэр эко системийн бүрэн бүтэн байдлыг хадгалж хамгаалах бүхий л нарийвчилсан юмнууд хийгдэнэ биз дээ? Эсвэл тэгдэггүй юм уу? Энэ тал дээр ямар юутай байгаа вэ?

Б.Бейсен: 3 номер хариулъя.

3.Батбаяр: ТЭЗҮ Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гарсны дараа одоо манай Монгол Улсад байж байгаа ус хамгааллын систем дотор усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд, энэ нь Усны газар засгийн газрын хэрэгжүүлэг агентлаг, сав газрын захиргаа, тэгээд аймаг, нийслэлийн Байгаль орчны газар гэсэн ийм 3 газар маань тухайн хэрэглэж байгаа, ашиглаж байгаа усны хэмжээ үр нөлөөллөөс нь шалтгаалаад ус ашиглуулах дүгнэлт гэж гаргадаг. Тэр дундаа яг энэ бүтээн байгуулалтын ажил дээр болохоор байгаль орчны нарийвчилсан үнэлгээ ТЭЗҮ-ийн дараа, нөгөө зураг төсөлд нь мэргэжлийн дүгнэлт гаргаж өгдөг. Тэгэхээр тэр зураг төсөлд нь мэргэжлийн дүгнэлт гаргахаар шууд хориглоод байгаа асуудал биш, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргаж өгөхдөө энэ асуудлууд нь ийм, ийм барилгуудыг ингэж, ингэж хийвэл голдоо нөлөөлөл нь бага байх нь байна. Голдоо нөлөөлөхгүй нь байна гэж гаргана. Жишээлбэл сая Нямбаатар даргын ярьж байгаа Туул голын хурдны замын асуудлыг бид маш их дэмжиж байгаа. Хэдийгээр голын хамгаалалтын бүс дотор байгаа ч гэсэн нөгөө үерийн хамгаалалтын бидний эвдчихсэн байсан далангаа өнгөрсөн 50, 60 жилийн хугацаанд эвдчихсэн байсан далангаа эргүүлээд хурдны зам барингаа сэргээх ингээд ийм бүтээн байгуулалтын ажилд давуу тал хүртэл бий болгож байгаа учраас дэмжиж байгаа.

Гэхдээ зөвхөн нэг барилга байгууламжийг барихын тулд юм уу, эсвэл нэг хэсэг барилга байгууламжийг барихын тулд голын хамгаалалтынхаа систем рүү, системд нь эвдрэл урвал оруулчих вий гэдэг үүднээс л Усны тухай хуулиа дагаж ярья. Түүнээс биш агаарын бохирдлын асуудал бол маш чухал асуудал. Гэхдээ

ойрын 10 жилийн асуудал. Усны тухай асуудал ирээдүй 100, 200 жилийн асуудал учраас тэрийгээ дагаж зохицуулалтаа хийвэл яасан юм бэ гэдэг. ТЭЗҮ юуны дараа байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дараа тэр 2 дээр үндэслэсэн усны мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргадаг гэсэн хариултыг хэлмээр байгаа юм.

Б.Бейсен: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүний асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Усны газрын даргаас асууя, Батбаяр даргаас асууя. Энэ онцгой хамгаалалтын бүсэд нийслэл Улаанбаатар хотод хэрэгжих инженерийн дэд бүтэц гэж, аймаг орон нутаг дээр болохгүй юу? Аймаг орон нутагт хэрэгжихгүй юу, зөвхөн Улаанбаатар хотынхонд болдог, бусад газар болохгүй юм уу гэж л асуумаар байна? Эхлээд нэг асуугаадахъя даа. Батбаяраас, яг мэргэжлийн хүнээс нь асуугаадахъя би.

Б.Бейсен: 3 номер хариулъя.

3.Батбаяр: Бүх голуудын хувьд ижил учраас танд бүх голуудын асуудлыг л жигдээр авах ёстой гэсэн хариулт байгаа.

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгвэл энэ дээр ингэж өөрчилмөөр байна. 1 дүгээрт нийслэл Улаанбаатар хот гэдгээ хэдүүлээ авъя. Ер нь инженерийн дэд бүтэц 1 дүгээрт, 2 дугаарт бүхий л инженерийн дэд бүтэц чинь байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдэнэ шүү дээ. Тэгэхээр энд хар даа байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийгдсэн инженерийн байгууламж гэж хэдүүлээ оруулъя. Инженерийн байгууламж, тэр гүүр, зам харгуй бүх л юмнууд чинь инженерийн байгууламжид орж байгаа биз дээ. Тэгэхээр ямар ч тохиолдолд нарийвчилсан үнэлгээ байгаль орчны үнэлгээ хийгдэнэ. Тийм болохоор 1 дүгээрт Улаанбаатар хот гэдгээ авъя. 2 дугаарт энэ дээр тэр байгаль орчны үнэлгээ хийгдсэн инженерийн дэд бүтэц, зам харгуй гээд бүр тодруулаад ч байдаг юм уу оруулаад ингээд явчихвал яасан юм бэ гэсэн нэг ийм санал байна. Ингээд оруулаад томьёолоод явчихъя. Уянга гишүүнээс томьёолол гаръя гэсэн энэ томьёолол дээр гарчихъя.

Нийтийн эзэмшлийн гээд тэгчихсэн байгаа. Нийтийн эзэмшлийн бус тодорхой хэмжээний дэд бүтэц хийгдэж болно шүү дээ. Зайлшгүй шаардлагатай л бол, хамгийн гол нь та нар юу хамгаалах гээд байгаа нь энэ усны саваа хамгаалах гээд байгаа бол усны савд чинь байгаль орчны үнэлгээ хийгдээд ямар нэгэн хор хөнөөл өгөхгүй л болоо шүү дээ тийм биз дээ? Хамгийн гол асуудал чинь энэ дээр логик нь энэ дээр байж байгаа шүү дээ. Тэгэхээр ерөөсөө нийтийнхээ бол азнаад, хамгийн гол нь байгаль орчны нарийвчлалын үнэлгээ бүхий инженерийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ гэсэн нэг ийм үг үсэг оруулаад л ингээд явчихвал яасан юм бэ л гэж байгаа юм. Шугам сүлжээ гэсэн үг үсэг орох нь дээр байх шүү.

Б.Бейсен: Санал хэллээ. Энэ Нямбаатар дарга Уянга гишүүнтэй та хамтраад сая Бат-Эрдэнэ гишүүний, Батжаргал гишүүний бүгдийн саналыг нэгтгээд тусгачхаарай. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Асуултаа асууя. Сая ярилаа шүү дээ тэр нөгөө нэг усны хамгаалалтын бүс тогтооно гээд. Тэр чинь далан барина даа, юм татна даа. Тэр

зардал хаанаас гарах вэ? Байгаль орчны яамнаас юм уу, хотоос юм уу 1? Энгийг би нөгөө тодруулж асууж байгаа шүү. Яагаад гэхээр наад Байгаль орчны яам чинь Усны газар чинь бүх зардлаа хасуулчихсан байхгүй юу тодотголоор. Тэгэхээр цалингийн зардалтай сууж байгаа хүмүүс. Тэгэхээр танайх хийчих юм уу? Ашгүй дээ. Захиалагч нь өөрсдөө хийдэг юм уу? Энэ 50 метрээс доошгүй зайд гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно гээд энэ арай ойрхон биш үү? Дээр би усны тухай Улаанбаатар хотын үйлдвэрлэлийн усны тухай танилцуулж байхад 18 мянган худаг байдаг, тэрний дийлэнх нь ундны усны хэрэгцээ хангаж чадахаа больсон гэсэн байсан байхгүй юу. Тэгэхээр 50 метр чинь арай л ойрхон биш үү? Тэгж л асууя.

Б.Бейсен: 5 номерт Нямбаатар гишүүн хариулъя.

Х.Нямбаатар: Мөнхбаясгалан гишүүнээ энэ ингэсэн юм 75 метр байсан юм. Тэгээд энэ урд нөгөө нэг Акуа Гардентай холбоотойгоор Барилга, хот байгуулалтын сайд, Байгаль орчны сайд хоёр 2019 онд байх, би, 22 онд, 22 онд энийг 50 метр болгочихсон юм. Одоо бид ингээд хэмжилт хийгээд үзэхээр Туул голын энэ онцгой хамгаалалтын бүсэд маш олон мянган барилга байгууламжууд баригдчихсан, дунд голын болон Сэлбэ голын хамгаалалтын бүсэд ингээд барилга байгууламжууд баригдчихаад байгаа юм. Тэгээд бид энэ 50 метр гэдэг энэ хэмжээг өөрчлөх шаардлагууд байгаа зарим газрууд дээрээ. 2 дугаарт саяын таны асуусан асуултад хариулахад энэ Туул голын хойд эргийг дагасан Туулын хурдны зам, Улаанбаатарын 1 дүгээр тойрог зам нь аль аль нь голын сав газрын тэр хүчитгэж далан байгуулах, хүчитгэх ажлуудыг төсөвт өртөгтөө багтааж магадлагдсан дүнгээрээ явж байгаа гэдгийг хэлье.

Б.Бейсен: 4 номер хариулъя. Уртнасан дарга.

Ц.Уртнасан: Ер нь бүтээн байгуулалт ч гэдэг юм уу, сайн сайхан зүйл хийх гэж байна гээд байгаль орчин руугаа довтлоод, тэр дундаа усныхаа энэ орчны хамгаалалтын бүсийг 75 байсныг 50 болгоод, 50-иа одоо ингээд багасгаад байж болно. Гэхдээ энэ үүдийг нээснээрээ гол устай тухайлбал Чингис хот байна Хэрлэн голтой, Баян-Өлгий Ховд голтой ч гэдэг юм уу энэ бүх суурин газруудын гол усны энэ хамгаалалтын бүс рүү чинь барилга байгууламж бариад ирэх ийм үүдийг нээж байна. Өнөөдөр Улаанбаатар хотын орчинд байгаа Туул голын чинь усны бохирдол ямар хэмжээнд хүрчихсэн байгаа гэдэг тодорхой лабораторийн шинжилгээнүүд, үнэлгээ дүгнэлтүүд гарчихсан байгаа. Тэгээд бид энэ асуудлыг бүтээн байгуулалт хэрэгтэй, сайн сайхан юм хэрэгтэй гэдэг талаар хандахаасаа илүүтэй дээрээсээ энэ байгаль орчинд нөлөөлөх байдлаа бид яах вэ, хэдий хугацаанд бид энэ Туул голтойгоо байх вэ гэдэг асуудал дээр ирчихсэн байгаа шүү. Тийм учраас эрхэм гишүүдийг энэ.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Ц.Уртнасан: Хуульдаа ингэж гар дүрээд байхаасаа илүүтэй бодитой байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээгээ хийгээд, ямар байна вэ гэдэг дүгнэлт дээрээ үндэслээд энэ бүтээн байгуулалтаа ярихгүй бол бодит байдал ийм байгаа шүү гэдгийг хэлье.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Саяын энэ Байгаль орчны яамны ТНБД-ын хариулж байгаатай холбоотойгоор яг бодлогын яам, Нийслэл 2 та нар ойлголцсон юм уу? Наадах чинь аягүй ноцтой юм ярьж байна шүү дээ. Тэгээд сүүлд нь ингээд бүүр 75 байсан 50 болгосон, одоо бүүр дотогшоогоо энэ эдийн засаг яах вэ, энэ экологи, байгаль орчноо хамгаалах руугаа бүүр сүйрсэн ийм хуулийн заалт орж ирэх гэж байгаа юм биш үү?

Нөгөө талдаа энүүгээр далимдуулаад хэлэхэд Нямбаатар даргыг юм хийх гээд байгааг ойлгож байна. Гэхдээ жоохон шинжлэх ухаанч, их тооцоотой, ул суурьтай хийхгүй бол би сая тэр манайх тэр нэг Зайсангийн эцэс рүү байдаг юм. Үгүй ээ тэнд нэг ийм тоглоомын, хүүхдийн тоглоом хийж байгаа биш дээ 2 хүүхэд айл гэр бүл тоглож байгаа юм шиг юм хийгээд, тэгээд 1 хэсэг гурвалжин, тэр эцэс дээр нэг гурвалжин юм хийчихсэн байсан өнөөдөр буулгаад хаячихсан байх юм. Ингэж болох юм уу? Тэр наана нэг зам нөхсөн байна, зүгээр машин овгоносон юм. Ямар улсууд хийгээд байна энэ зам харгуйг чинь. Тийм учраас энийгээ бодолцож хийгээрэй. Юм хийж болно, гэхдээ их тооцоотой хийхгүй бол сая тэр Зайсангийн эцэс бол арай дэндүү, автобус нь эргэж болохоо байчихсан, дээрээс нь тэрийгээ ахиад өнөө өглөө буулгаад хаячихсан байх юм энэ чинь. Тэгээд замыг нь баахан ухаад нэг ийм гурвалжин нүх үлдээгээд, би зургийг нь авчихсан л байна л даа. Үгүй ээ тэгж юу яаж болдог юм уу улсын төсвийн мөнгөөр? Тэгээд нэг ийм хачин гурвалжин юм хийгээд орхичихсон. Нөгөө бүүр замыг нь огтлоод авсан байхгүй юу. Тэгснээ нэг ийм бордуурууд хийсэн юм хашлага юм, сүүлдээ тэрийгээ өнөөдөр бүүр аваад хаячихсан. Юмыг ингэж хийж болохгүй. Тийм учраас шинжлэх ухааны тооцоотой аливаад ул суурьтай хандаж байхгүй бол наад энэ 50 метр гэдэг чинь сүүлдээ нөгөө тийм юм болчих вий. Далан. Үгүй ээ сая байгаль орчны, яах вэ 50, 75 нь яах вэ, Байгаль орчны яамны байр суурийг би сонсоод ийм бодол төрлөө.

Б.Бейсен: Асуулт асуусан уу, үг хэлсэн үү? Үг хэлсэн юм байна. Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Нийслэл Улаанбаатарын өнгө төрх сайжирч байгаа. Энийг би хаана ч хэлнэ. Ганбаатар гишүүнээ наадхаа хотын иргэдийн хурал дээр очиж ярь л даа. Наад Зайсангийн тэр гурвалжин энэ Их Хурлын Байнгын хороон дээр яриад байх асуудал мөн юм уу. Юун дээр наад Туул гол, ер нь энэ Улаанбаатар хотын энэ гол горхитой холбоотой, Туул голын арчлалтай холбоотой олон асуудлууд ер нь хэцүү л болсон юм билээ дээ. Тэгээд өнөөдөр мэдсэн юм шиг юм ярьж болохгүй л дээ. Байгаль орчны яамныхан бол энэ Туул голын, энэ Богд уулын хойд талын тэр энгэр ам тэгээд бүгд дүүрсэн юм байна лээ шүү дээ. Тэгээд өнөөдөр гэв гэнэт юм мэдсэн юм шиг байгаль орчиндоо хайртай царайлах хэрэггүй. Та нар ингээд энэ Маршалын гүүрээр гараад зүүн тийшээ яваарай, Sky-аас цаашаа гараарай, шинэ, шинэ хотхонууд бүгд босож байгаа шүү. Тэгээд тэрийгээ нэг их аялал жуулчлал гэж харваас орон сууц байхгүй юу. Тэгээд 5 ханатай гэр нэг шөнө барьчихдаг шиг тийм ээ, 5 ханатай гэрийг нэг шөнө барьчихад өглөө нь гайхна. 5 давхар байшин хэдэн 10-аар нь сүндэрлүүлж байхад мэдээгүй байж, өнөөдөр тийм юм яриад хэрэггүй, зохихгүй байна гэж хэлнэ би.

Харин ч бүүр одоо тэр шинэ баригдаад байгаанууд нь хэний үед олгогдсон газрууд өнөөдөр тэр хотхон болоод байгааг нь шалгачих хэрэгтэй байхгүй юу. Наад гол горхитой холбоотой асуудлууд харин ч бүүр хамгаалъя л гэж байгаа юм байна шүү дээ. Тийм. Харин зүгээр тэр орон нутаг дахь байгаа тэр зүйлүүдээ нэг оруулж өгөөд, зохистой хэмжээнд нь тавьж өгөөд, ингээд энэ ажлаа явуулахгүй

бол ЗГ дээрээсээ дэмжигдэж орж ирчхээд Төрийн нарийн бичгийн үүрэг гүйцэтгэгч та ингээд ЗГ-ынхаа шийдвэрийг үгүйсгээд, ингээд яриад байх хэрэггүй шүү дээ. Та бол өнөөдөр харин бараг Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг яагаад тийш нь шилжүүлсэн бэ гэдгийг тайлбарлаад л сууж байх ёстой хүн гэж би таныг хардаг шүү. Шударга ёс гэж байдаг бол. Баярлалаа.

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Нэг ийм Нямбаатар дарга ийм асуудал байна л даа. Энэ голын эрэг усны асуудал дээр тэр 50 метр, 75 метр дээр онцгой анхаарах нэг санал байна. Үерийн ус юм уу, эрэг газруудаар усанд ихээр идэгддэг газар тэгээд сүүлдээ юм гардаг. Энэ дээр анхаараад газар олголтын асуудал дээр нь анхаарахгүй бол тэгээд нөгөө голын эрэг дээр жишээлбэл Туул гол, Баян-Өлгий аймгийн Ховд гол эрэг ойрхон бүр тулаад барьчихсан асуудлууд байж байгаа байхгүй юу. Тэгээд үерийн ус ямар нэгэн юм гарахад тэгээд нөгөөдөх нь усанд автлаа гээд ийм асуудал гаргаад байдаг. Тэгэхээр чинь энэ 50, 100 метр гэдэг дээр нь яг газар олголт дээр нь тэрнийг онцгой анхаараад, аль эсвэл нүүлгэх юм уу тийм арга хэмжээ авахгүй бол бас л онцгой байдалд тэр үед нь хүндрэл учруулах тал байгаа гэдгээ хэлье. Санал хураалт байгаа шүү гишүүдээ. Ундраа гишүүн. Саналаа хурдан нэгтгэчихээрээ наадахаа. Батжаргал гишүүн таны санал орсон уу? Санал Уянга гишүүн, Батжаргал гишүүн санал гаргасан, Ганхүлэг гишүүн. Саналын томъёоллыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн зүйлийн бүсэд гэсний дараа инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад гэж нэмэх, өөрчлөх. Нийслэл Улаанбаатар гэдгээ аваад хаячихлаа шүү дээ тэгээд, авчихсан байгаа биз дээ. Дахиад унших гэж байна. Төслийн 1 дүгээр зүйлийг, зүйлийн бүсэд гэсний дараа инженерийн дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжаас бусад гэж нэмэх. Дэд бүтэц дотор орчихгүй юм уу энэ чинь инженерийн байгууламж. Энэ саналын томъёоллыг танилцууллаа. Гишүүд санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. 66,7 хувиар санал дэмжигдлээ. Найдалаа гишүүний дэмжсэнээр авъя.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу, нэрсээ өгөөрэй? Байхгүй байна. Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг, хуулийн төслийг хэлэлцсэн талаарх байнгын хорооны санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Дараагийн хэлэлцэх асуудалд оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Нямбаатар дарга урилга нь бэлэгтэйгээ биз дээ.

12.26 цаг

Хоёр. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Дараагийн асуудалд оръё. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Төслийн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна.

М.Ганхүлэг: 2 дахь асуудлыг ажлын хэсгээс дахиж оруулж ирсэн байгаа юм. Өмнөх Байнгын хорооны шийдвэрийн дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. 2017 онд батлагдсан Малын генетик, нөөцийг, төлөв байдлыг үндсэндээ үнэлэх энэ хуультай холбогдолтой асуудлыг бид бүхэн хэлэлцсэн байгаа юм. Энэ хүрээнд 5, 3 агуулга, дэд үндсэндээ 5 санал бүхий 3Г-т чиглэл өгөх тухай тогтоолын төслийг бид бүхэн Байнгын хороогоороо 80 гаруй хувийн саналаар баталсан. Тэгээд ажлын хэсэг чуулган руу орохоос өмнө тодорхой нэр бүхий гишүүд, ажлын хэсгийн гишүүд маань хоорондоо зөвлөлдөөд, мөн Улсын Их Хурлын шинэ парламент, ялангуяа энэ хяналт шалгалт, түүнтэй холбогдолтой асуудлууд дээр илүү нээлттэй байх гэдэг үндсэн Их Хурлын бодлогыг харгалзан үзээд, яг энэ нэлээн 4 дэх агуулгын хүрээнд үржлийн мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааны бүртгэл, хяналтыг сайжруулах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх гэдэг энэхүү хяналт шалгалттай холбогдолтой заалтыг нь хасъя. Тодорхой Гаалийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, бусад хууль тогтоомжоороо хяналт шалгалтын асуудлууд нь бүгд үндсэндээ шийдэгдээд явж байгаа учраас нэмж энд оруулж ирэхгүйгээр энэ 4 дэх агуулгыг хасаад, хуучин бидний баталсан бусад агуулгаараа үг үсгийн хувьд ижил байдлаар оруулъя гэсэн саналыг оруулж байгаа юм. Тийм учраас Байнгын хорооны гишүүд маань дахин энэхүү тогтоолын төслийг харж, дэмжиж өгөхийг хүсье.

Б.Бейсен: Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Ц.Мөнхнасан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулалтын газрын дарга, Б.Батбаатар Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Д.Гантулга Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, Т.Балжинням Мал, эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл судалгаа, статистикийн газрын дарга, Г.Сувдаа судлаач, доктор. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу, нэрсээ өгнө үү? Наранбаатар гишүүнээр тасалъя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн, Наранбаатар гишүүний асуулт асууя. Энэ ирцээр нь орчихсон байна.

Н.Наранбаатар: Тогтоолын төсөлтэй танилцсан. Тэгээд ойлгохдоо энэ 26-аас 36 он хүртэл гаднаас үржлийн адуу оруулж ирэхийг л хориглох байгаа юм байна гэж ойлгосон. Зорилго нь тодорхой байх. Монгол адуугаа хамгаалах, тэгээд Монгол адууны удмын генетик нөөцийг хамгаалахад чиглэгдсэн ийм л тогтоолын төсөл байгаа байх гэж бодож байгаа юм. Энэ төрийн бус байгууллагууд, уяачид энэ малчдаасаа хэр асуусан юм, хэлэлцүүлгүүдийг ямар хэмжээнд хийсэн юм гэдэг дээр тодруулъя.

Б.Бейсен: Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Тогтоолын төслийн үндсэн агуулга дээр гол бидний зорилго бол энэ Малын генетик, нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой ийм агуулга байгаа. Энэ хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн яам, мэргэжлийн байгууллагууд дээр өмнө нь хуулийн хэрэгжилттэй холбогдолтой үнэлгээнүүдийг нэлээдгүй хэмжээгээр хийсэн ийм тайлангуудыг бид бүхэн өмнөх ажлын хэсгийн дүгнэлт дээрээ танилцуулсан байгаа. Түүнтэй холбогдуулан хамгийн гол заалт нь үржлийн адуу, түүний үр хөврөл импортлох энэ байдлыг 2026 оноос эхлэн тодорхой хугацаанд хориглохтой холбогдолтой ийм заалт орж ирж байгаа. Үүнийг Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа 20, 30 жилийн

түүхтэй мэргэжлийн холбоод, ялангуяа Монголын морин спорт, уяачдын холбоо, Монголын үндэсний морин спорт, уяачдын холбооныхон аль аль нь дэд ажлын хэсэгт ажиллаж, өөрсдийн өмнөх хугацаанд хийсэн судалгаа, материал бүх зүйлүүдээ бид бүхэнд ирүүлж, албан ёсоор энэ тогтоолын төслийн агуулгыг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлсэн байгаа.

Мөн дээрээс нь бид бүхэн маш өргөн хүрээнд зүүн бүсийн гишүүдийн тодорхой ажлын хэсэг орон нутагт ажиллах хугацаанд иргэдээс гарч ирсэн саналыг эрэмбэлсэн байгаа. Энэхүү саналын дийлэнх үндсэндээ агуулгад нь тодорхой энэ үржлийн адууг хязгаарлахтай холбогдолтой саналууд иргэд, олон нийтээс ирсэн ийм дүгнэлтүүд гарсан байгаа. 2019 онд бид бүхэн Малын генетик, нөөцийн тухай хуулиараа Монгол малын энэ төлөв байдлын үнэлгээг үндсэндээ хийж, Нэгдсэн Үндэстний Байгууллагад үндсэндээ илгээсэн байгаа. Энэхүү илгээсэн тодорхой судалгааны үр дүнд тодорхой үр дүнгүүд үндсэндээ харж болно. Ялангуяа адуун сүргийнхээ бид бүхэн 30,8 хувийг тодорхой үржил селекцийн байдал, гений байдлыг нь үндсэндээ тодорхойлж чадахгүй байгаа ийм нөхцөл байдал үүссэн байгаа. Тэгээд үүнтэй холбогдолтой энэхүү тогтоолын төслийг бид бүхэн гол үндэслэл болгон гаргаж байгаа юм.

Олон улсын түвшиндээ бид бүхэн зөвлөж байгаагаар нийт сүргийн 10-аас дээш хувийг бид бүхэн тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд тодорхой эрсдэл үүснэ гэдэг ийм нөхцөл байдал үүсдэг байгаа. Тийм учраас цаашдаа бид бүхэн энэ Генетик нөөцийн тухай хуулиараа бүртгэл энэ мэдээллүүдийг сайжруулах чиглэлийн эдгээр дүгнэлтүүдийг үндсэндээ авч хэрэгжүүлэх заалтыг тогтоолын төсөлдөө оруулсан байгаа гэдгийг дурдъя.

Б.Бейсен: Тийм ганцхан заалт. 4 дэх зүйлийг. Ганхүлэг гишүүн хассан заалтыг нь. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Бат-Эрдэнэ гишүүд асуулт асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 4 дүгээр заалтыг нь хасаж байгаа юм уу? Би хөндөгдөөгүй заалттай л холбоотой асуулт асуух гээд байх юм.

Б.Бейсен: Өмнө нь яриад.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо ингэж байгаа юм байна шүү дээ. Гаднаас мал оруулж ирэхгүй, энэ чинь үржлийн адуу оруулж ирэхгүй гэж байгаа юм байна. Оруулж ирснээ яах юм бэ, хэрэгцээ байхгүй болчихсон юм уу? Ер нь ген, малын генийг алдуулаад байна гэж байгаа бол бүүр хорих ёстой юм биш үү? Зөвхөн импортоор оруулж ирэхийг нь хорьж байгаа бол энэ шал ондоо агуулга байна шүү дээ. Энд орж ирснийг нь тэгвэл давуу эрх олгож байна гэж харах гээд байна шүү дээ. Хэрвээ үнэхээр хортой байгаад, Монгол адуунд нөлөөлөөд, Монгол адууны генийг устгаж байгаа бол бүр хорих хэрэгтэй байна шүү дээ. Яагаад тэгвэл уралдуулаад байгаа юм бэ, яагаад уралдаад түрүүлээд ирснийг нь шагнаад байгаа юм бэ, яагаад урамшуулаад байгаа юм бэ, яагаад тэр уралдаад ороод ирснийг нь тэгвэл бүр цол хэргэм өгөөд бүр дээшээ манлай тод, манлай эд нар болгоод байгаа юм бэ? Үгүй ээ хэрвээ болохгүй байгаа энэ хүмүүсийг хөхиүлэн дэмжиж байх хэрэг юу байгаа юм бэ? Хэрвээ бодлогоо гаргая гэж байгаа бол бүхэлд нь томоор нь гаргах хэрэгтэй шүү дээ.

Хэрвээ үнэхээр л гентэйгээ, Монгол адууны ген алдагдаад байна гэж байгаа бол энэ гентэй холбоотой, энэ генийг хамгаалахын тулд өөр арга хэмжээнүүдээ оруулж ир л дээ энэ дотор. Тэр талаас нь тэгвэл дэмжье. Өөр олон зөндөө арга хэмжээнүүд байна шүү дээ. Тэгээд оруулж ирснийг нь болохоор ген хамгаалж байгаа гэсэн нэрийн доор, бусдыг нь болохоор хөхиүлэн дэмжээд, урамшуулаад, шагнаад, алдаршуулаад байгаа мөртөө яг хилээр орж ирэхийг нь хорино гэхээр би бол энийг үнэхээр ойлгохгүй л байна. Энэний цаана ямар юм явж байгаа юм бэ, нөгөө хардах эрхтэй гэдэг шиг хардах эрхтэй л байна шүү дээ. Яг ийм арга хэмжээ авч болохгүй. Жишээ нь Булган аймаг адуу, айргаараа алдартай, айргаа илүү сайжруулъя л даа, айргийнхаа гарцыг сайжруулъя, үржлийн тийм сүүний чиглэлийн адуу яагаад оруулж ирж болохгүй гэж, болно шүү дээ. Тэгвэл энэ хаагдах уу? Яг энэнтэй уялдуулаад илүү тэр бүүр ген алдагдуулаад байгаа бол, Монгол үхрийн ген алдагдаж байгаа бол гаднаас орж ирж байгаа герефордоо хаая л даа тэгвэл, тэр сүүний чиглэлийн янз янзын үхрүүдээ хаая л даа. Тэгээд ийм богинохон хүрээнд сэтгэсэн ийм хууль мэдэхгүй, тогтоол Улсын Их Хурлаас гаргана гэдэг мэдэхгүй. Би жишээ нь ичиж байна. Ийм байж болохгүй байх.

Б.Бейсен: Ажлын хэсгээс хэдэн номер хариулах вэ? Ганхүлэг гишүүн хариулъя.

М.Ганхүлэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нэмэлтээр манай дэд ажлын хэсгийнхэн хариулах байх. Ажлын хэсэг дээр яах вэ бид судалгаа тооцооллуудыг харсан. Яг өнөөдрийн яг таны хэлж байгаа тодорхой суурь асуудлыг шийдэх гол асуудал нь энэ тодорхой хугацаанд хязгаарлахтай холбогдолтой ийм заалт, агуулга байгаа юм. Бид энэ хугацаанд малын үе солигдох хугацааг янз янзын байдлаар тооцоолж манай эрдэмтэд танилцуулсан. Тэр утгаараа бид бүхэн 10 жил гэдэг энэ хугацааг оруулж ирж байгаа. Малын төлөв байдлын үнэлгээгээ бид бүхэн 3 жил давтамжтайгаар 2-оос 3 удаа бид бүхэн хийх үндэслэл бүрдэнэ. Яг таны саяын ярьж байгаа ямар чиглэлээр, яаж үржүүлж, хөгжүүлэх вэ, ер нь аль ямар стратегитай байх вэ гэдэг энэ байдлыг үндсэндээ бүрэн дүүрэн тодорхойлох тооцоо судалгаа бол 6 жил алдагдсан байгаа юм.

Тийм учраас асуудлыг сууриар нь шийдье гэж бодсон боловч өнөөдрийн байдлаар үндсэндээ судалгаа тооцооллын нөхцөл байдлууд бол тодорхой хуулийн хэрэгжилттэй холбогдолтойгоор бүрэн дүүрэн биш байгаа ийм ажлын хэсгийн дүгнэлт гарч байгаа юм. Тийм учраас энэ удаагийн ажлын хэсгийн хамгийн эхний заалт дээр энэхүү асуудлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг сууриар нь авч хэрэгжүүлэх гэдэг таны саналыг нэмэлтээр оруулж ирж байгаа гэдгийг та ойлгоорой. Ялангуяа сүүлийн жилүүдэд гаалиар 5700, сүүлийн 10 жилд 5700 үржлийн адуу орж ирсэн байгаа юм. Үүний дийлэнх хэсэг нь хурдны зориулалттай бол орж ирж байгаа, маш цөөхөн хэсэг нь таны ярьж байгаа тодорхой бусад төрлүүд дээр үндсэндээ орж ирж байгаа. Тэгэхээр бид бүхэн үндсэн суурь асуудлаа үндсэндээ шийдэхийн тулд махны чиглэлийн, сүүний чиглэлийн бусад үржлийн адууг ч гэсэндээ түр хугацаанд хязгаарлаж, стратегийн тодорхой асуудлуудаа шийдье гэсэн ийм бодолтой орж ирж байгаа юм.

Энэ тогтоолын төсөл хэрэгжсэнээрээ бид бүхэн асуудлыг гол үндэс сууриар нь шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ. Ингээд зөвхөн тогтоол батлагдаад бүх асуудал шийдэгдэхгүй ч гэсэндээ тодорхой эхний алхмууд хийгдэх боломжууд нь бүрдэнэ. Төлөв байдлын үнэлгээ энэ зүйлүүдийг бид хийх явцад нэмэлтээр байнгын үржлийн зориулалттай адуу орж ирээд байгаа учраас тэр дүгнэлт тайлангуудыг яг

үнэн зөвөөр гаргахад хүндрэлүүд учирч байгаа ийм нөхцөл байдлууд байгаа юм гэдгийг онцолж хэлье. Тэгээд манай дэд ажлын хэсэгт Мал эмнэлгийн хүрээлэн, мал эмнэлгийн байгууллага, мэргэжлийнхэн байгаа. Тэгэхээр гишүүдийн асуултад нэмэлтээр хариулт өгөх нь зөв байх.

Б.Бейсен: Ажлын хэсгээс хэдэн номер хариулах уу? 5 номер. Ажлын газрын хэдэн номер хариулах юм бэ? 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн хорооноос гаргасан, батлагдсан арга зүйн дагуу 2018, 2017 онд малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээг хамгийн сүүлд хийсэн. Энэхүү үнэлгээгээр Монгол Улсын нийт адуун сүргийн 30,8 хувь нь ашиг шимийн чиглэлийг дахин тодорхойлох шаардлагатай гэсэн үнэлгээ дүгнэлт гарсан байдаг. Энэ дүгнэлтээс хойш одоогоор малын адуун сүргийн генетик нөөцийн төлөв байдлын тайлан судалгаа хийгдээгүй байгаа. Энэхүү судалгаа хийх хугацаанд хийгээд дараа нь адуун сүргийнхээ, нийт адуун сүргийнхээ ашиг шимийн бөгөөд генетик нөөцийн төлөв байдлынх нь тайланг шинэчлэн гаргасан гаргах хүртэл хугацаанд энэ зохицуулалтыг хийж өгөөч гэдэг байдлаас хандаж байгаа юм.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Б.Батбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ импортоор орж байгаа орж ирж байгаа адуу бүгд бол БТКУС кодоороо нэг буюу нийт 5209 импортын үржлийн адуу орж ирсэн байгаа. Бат-Эрдэнэ гишүүний таны асуусан асуултын дагуу ер нь бид энэ дотроо Батжаргал гишүүн түрүүн ч ярьж байсан урдах Байнгын хороон дээр. Нөгөө махны чиглэлийн, сүүний чиглэлийн, хурдны чиглэлийн гээд ингээд нөгөө бид төрлөөр нь, ашиг шинж чанараар нь тодорхойлох ийм нөгөө тодорхой боломж байхгүй. Тэгсэн хэр нь Монгол Улсын ЗГ-аас 5 төрлийн малыг нөгөө үржүүлэх стратеги төлөвлөгөө гээд баталчихсан. Гэтэл тэр төлөвлөгөө дээрээ нөгөө заагдсан бүс нутгаасаа өөр бүс нутагт энэ нөгөө үржлийг нөгөө мэргэжлийн нөгөө тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөр бүс нутагт үржүүлдэг, өөр бүс нутагт арилжаалдаг ийм асуудлууд байна. Тэгээд энэ асуудлаар Монголын морин спорт, уяачдын холбоо тэргүүлэгчдийнхээ хуралдаанаар хэлэлцээд, энэ гишүүдийн санаачилсан энэ ЗГ-т чиглэл өгөх тухай тогтоолын төслийг.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Уяачдын холбооноос ямар шийдвэр гарсан юм бэ? Үнэхээр импортын адуу Монгол адууны генийг устгаад байна, тийм болохоор хор хөнөөл учруулаад байна. Тийм болохоор энийг больё гэсэн ийм шийдвэр гарсан юм уу, эсвэл үнэхээр хангалттай хэдүүлээ сайхан адуугаа оруулаад ирлээ, хэдүүлээ үржүүлгээ хийчихлээ, одоо дахиж үржүүлэг хийхгүй, хэдүүлээ оруулж ирсэн дээрээ үржүүлэг хийчихье, бид бүхэн хангалттай оруулаад ирлээ гэсэн шийдвэр гарсан юм уу? Ийм л асуудал наадах чинь тусаж байна шүү дээ.

Б.Бейсен: 6 номер хариулъя.

Б.Батбаатар: Юун дээр энэ дэд ажлын хэсэгт Монголын морин спорт, уяачдын холбоо, тэгээд Үндэсний морин уралдаан, уяачдын холбоо ажлын хэсэгт

орсон. Ажлын хэсэгт орохдоо БОХХАА-н байнгын хороон дээр Генетик, нөөцийн тухай хуулийн хэрэгжилт, тэгээд энэ дундаа Хөдөө аж ахуйн байнгын хорооноос баталсан удирдамжийн дагуу Монгол адууны ген фондыг хамгаалах асуудлаар тодорхой нөгөө адууны төлөв байдлын тухай танилцуулга явуулсан. Үүнтэй холбогдуулаад Үндэсний морин уралдаан, уяачдын холбооноос Их хурлаараа энэ асуудлыг хэлэлцээд, шийдвэр гаргасан юм байна. Монголын морин спорт, уяачдын холбооноос энэ асуудлаар бол Тэргүүлэгчдийнхээ хуралдаанаар хуралдаж шийдвэр гаргасан. Ер нь бол одоо байгаагаа нутагшуулъя, тэр стратеги төлөвлөгөөнийх нь дагуу энэ үржлийнхээ ажлыг төлөвлөж, зохион байгуулах ёстой гэсэн ийм байр суурь дээр нэгдсэн байна лээ.

Б.Бейсен: 6 номер нэмж хариулъя.

Д.Гантулга: Гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. 2017 онд Бат-Эрдэнэ гишүүн бид ингээд хамтдаа л баталсан хууль Малын генетик нөөцийн тухай хууль тийм ээ. Тэгээд энэ хууль малын ген фондоо бүртгэлжүүлнэ, хадгална, хамгаална. Үндсэн хуулиар заагдсан мал бол төрийн өмч, Үндсэн хуулиар хамгаалагдах ёстой. Тэгэхээр энэ малаа хамгаална гэсэн үг биш, удмын санг нь хамгаална, ген фондыг нь хамгаална гэсэн ийм Үндсэн хуулиар хуулийн өмнө хүлээсэн үүрэгтэй. Тэгээд тэр үүргээрээ энэ хуулийг баталсан боловч энэ хуулийн хүрээнд 3 жил тутам удмын сангийн тэр удам зүйн талаас нь дүгнэлтүүд гаргаад явж байх ёстой байтал энийг Хөдөө аж ахуйн яам маань яг үндсэндээ санхүүгийн боломж бололцоо, янз бүрийн асуудлаасаа болоод 3 жил тутамдаа хийлгүй өнөөдөр олон жил болчихсон байна. 6 жил болчихоод байна уу, 6 жил болчихоод байна. Цаашдаа, одоо та ингэж хэлээд байна шүү дээ. Орж ирсэн тэр 5 мянга хэдийгээ яах юм бэ гээд. Энэ чинь 10 жилийн хугацаанд орж ирсэн учраас зарим нь үхэж үрэгдсэн байгаа. Сая сүүлийн.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Удмын сангаа хамгаалъя гэдэг Удмын сангийн тухай хуулиа хэрэгжүүлбэ гэж байгаа чинь маш сайн байна, маш сайн байна, би хөхиүлэн дэмжмээр байна. Өөр бусад мал дээрээ тавьчихъя тэгвэл. Үхрээ оруулж ирэхээ больё, хонио оруулж ирэхээ больё, тэгээд удмын сангийнхаа тэр жил тутам дүнг нь гаргаад ингээд Хөдөө аж ахуйн яам ажилладгаараа ингээд ажиллая. Заавал яагаад адуу юм бэ? Үхрээ больчихъё хэдүүлээ тэр сүүний энээ тэрээ гэсэн, махны чиглэлийн үхэр оруулж ирээд эндээ үржүүлээд байдгаа больчихъё л доо тэгвэл.

Б.Бейсен: 6 номер гүйцээж хариулъя.

Д.Гантулга: Бид маш сайн ойлгож байгаа. Адууны тухай асуудлыг би залуу уяачдын холбоо байгуулаад 21 аймаг тойрч явсан. Үндэсний хэмжээнд энэ уяачдын асуудал дээр би багцаалдана. Уяачдын холбооны өнгөрсөн их хурлын би дүрмийн ажлын хэсэг, баримт бичгийн ажлын хэсэг ахалж ажилласан. Уяачид дээр энэ бол маш том эрх ашиг гэдгийг би ойлгож байгаа. Гэхдээ нэг л юм байгаа юм. Ямар ч ноосны чиглэлийн хуцыг айл амьтан дамжуулаад хонь хурга аваачаад нийлүүлээд нийлэгжүүлдэггүй юм. Ямар ч бухыг тэгээд явахгүй байгаа юм. Харин азаргыг яаж байгаа вэ зүчээд нь аваачаад амьтан хүн болгон гүүгээ аваачиж гишгүүлээд, хаашаа энэ удам тэр үржүүлэг яаж явж байгаа бол зах замбараагаа алдсан. Энэ бол тоо хэм хэмжээнээсээ хэтэрсэн. Энэ бол шинжлэх ухааны мал

эмнэлгийн энэ хүрээлэнгүүдээс гаргаж байгаа санал, зөвлөмжийг давсан. Энэ тоо бол замбараагаа алдсан. Энийг бид мэдэж байгаа.

Цаашлаад энэний ард бид Монгол энэ сүлдэндээ залсан Монгол адууныхаа ген фондыг хамгаалах энэ 30,8 хувьд хүрчихсэн гэдэг асуудал яригдаж байгаа байхгүй юу удам зүйг нь бид тодорхойлж, ашиг шимийг нь тодорхойлж чадахгүй. Бид үхэр дээр тийм асуудал яригдаагүй, ямаан дээр яригдаагүй, тэмээн дээр яригдаагүй, хонин дээр яригдаагүй байгаа юм. Энэ бол зөвхөн адуун дээр яг ний нуугүй хэлэхэд энэ уяачдын ашиг хонжоо олох зорилгоор хэт замбараагүй үржүүлэг нэрийн доор ашиг олох зорилгоор хийсэн энэ ажиллагаа чинь өөрөө зах замбараагаа алдсан учраас адуун дээр энэ асуудлыг ярихаас өөр асуудал шийдэлгүй болсон. Тэгээд энэ жилийн хувьд.../минут дуусав/

Б.Бейсен: Таны тодруулах дууссан. Ганхүлэг гишүүн. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Би асуусны дараа тодруулчихъя, тэгвэл ахиад тодруулга хийхдээ хэлчих байх.

Б.Бейсен: Тодруулга өгье, хэдэн номер өгөх юм бэ?

Г.Ганбаатар: Энэ микрофон ажиллаж байгаа юм уу. 3 асуулт байна. 1 дүгээрт нь хамгийн түрүүнд тэр малын генетик удмын сан, Монгол адууны тэр үүлдэр угсаа хамгаалж байгаад чинь санал нэг байна. Гэхдээ та нөхдийн ярьж байгаа тоо түрүүнд яам болохлоор 5700 үржлийн адуу гээд, сая хариулж байгаа тодруулж байгаа нөхөд 5200 үржлийн адуу гээд 1 дүгээрт энэ наад тоогоо нэгтгэх, 500 үржлийн адуу гэдэг чинь их тоо шүү, 2 өөр тоо яригдаад байна.

2 дугаарт нь энэ үржлийн адуун дотор чинь махны чиглэлийн үржлийн адуу орж байгаа юу? Дан хурдны удмынх уу? 2 дугаарт энэ тогтоол гарснаар махны чиглэлийн үржлийн адуу нь яах юм бэ? Гаднаас ингээд адууны үржлийг тэр чигээр нь ингээд хорьчихвол энэ дотор чинь нөгөө бусад төрлийн нүдийг нь авах, үгүй ээ нуухыг нь авах гэж байгаад нүдийг нь сохолно гэдэг шиг бусад төрлийн үржлийн адууг ингээд хаачих юм уу? Юмыг хорих амархан. Би юу гэж харж байна вэ гэхлээр тэр 5700 байна уу, 5200 байна уу тэр үржлийн адуунуудаа оруулж ирсэн нөхдүүд үржлийнхээ адуун сүргийг өсгөчхөөд, одоо хаалгаа хаачихъя, дээрээс нь жоохон гаднаас орж ирэхгүй юм чинь үнээ өсгөчихье гэсэн ийм бодлого явж байгаа юм биш гэсэн хар төрж эхэлж байна. Энэ дээр яг ямар байр суурь байгаа юм бэ?

3 дахь асуулт нь тэр 30,8 хувийн ашиг шимийг дахин тодорхойлох гэж хэлж байгаа байхгүй юу. Ашиг шимийг дахин тодорхойлох гэж өөрөө ярьсан. Ашиг шимийг дахин тодорхойлох гэдэг чинь нийт Монгол Улсын адуун сүргийн 30,8 хувь яг дан ийм эрлийз болчихлоо гэсэн үг юм уу? Сая зарим хариулж байгаа нөхдүүд чинь нийт адуун сүргийн чинь 30,8 хувь ерөөсөө замбараагүй үржүүлэг явуулаад эрлийз болчихлоо гэсэн юм ярьж байна шүү дээ. Энэ 2 чинь уг нь их өөр ойлголт шүү дээ. Энэ дээр тодруулга авъя. Энэ 3-ыг хариултаа авч байгаад дараагийнхаа тодруулгыг хийе.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэд байдаг мэргэжлийн хорооноос болохоор малын генетик нөөцийн төлөв байдалд нь эрсдэлгүй, эрсдэлтэй, тодорхойгүй гэсэн 3 шалгуураар үнэлгээ өгч байгаа. Манайхаас одоогийн байдлаар эрсдэлтэй, адуун сүргийн генетик нөөцийн хувьд эрсдэлтэй дүгнэлтэд хамрагдаагүй, тодорхойгүй дүгнэлтэд хамрагдсан байгаа. Тодорхойгүй гэдэг нь юу гэсэн үг вэ гэхээр энэ нь яг Монгол үүлдэр омгийн үгүй бол Англи, Араб үүлдэр омгийн адууныхаа хэв шинжид хамаарч байна уу, эсвэл өөр хэв шинжид хамаараад байгаа юм уу гэдгийг ялгаж салгахгүй байгаа. Ялгаж салгах шаардлагатай гэдгийг илэрхийлж байгаа ийм ангилалтын дүн гэж ингэж ойлгож болно. Тийм учраас Монгол улсад Монгол адуу маань өөрөө мах, сүү, уналга эдэлгээний чиглэлийн ашиг шимийн чиглэлтэй адуу, ашиг шимийн чиглэлийг нь төрөлжүүлээд ашиг шимийн тухайн үзүүлэлтээр нь дотор нь шилж сонгоод үржүүлж байгаа. Энэ Монгол адуу нь өөрөө махны, сүүний ашиг шимийн чиглэлтэй учраас энэ дотооддоо махны бөгөөд сүүний үйлдвэрлэлийг, Монгол адууныхаа нөөцийг ашиглаад үйлдвэрлэлээ хийгээд явуулаад байх ийм боломжтой гэж үзэж байгаа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч Ганхүлэг гишүүн нэмж хариулъя. Нэмж хариулчхаад дараа нь хариулах гээд байна.

М.Ганхүлэг: Гаальтай холбогдолтой юун дээр сүүлийн 2015 оноос хойш 10 жилийн хугацаанд нийтдээ 5209 үржлийн адуу импортоор орж ирсэн байна. Жилд дунджаар 500 орчим гэж үндсэндээ тооцож болно. Хамгийн өндөр нь 2022 онд 937 адуу бүртгэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 3138 байгаа юм. Таны асууж байгаа яг дотор нь нэр төрлөөр нь тодорхой үндсэндээ нарийвчилсан мэдээллийг үндсэндээ гаргаж өгөх боломжгүйгээр ажлын хэсэгт гаргаж өгөөгүй учраас яг төчнөөн хувьтай гэдэг байдлаар хариулах боломжгүй байна. Энийг цаашдаа энэ орж ирж байгаа бүртгэл мэдээлэл дээр илүү сайжруулах шаардлагатай гэдэг дүгнэлтийг ажлын хэсэг дээрээ бид бүхэн оруулсан байгаа. Ер нь дийлэнх нь хурдны чиглэлээр орж ирж, орж ирсэн байна гэдгийг хэлье.

Б.Бейсен: Ажлын хэсгийнхэн энэ гишүүдийн асуусан асуултад тодорхой хариулаарай. Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Би бас нэг асуулт нь тэр 30,8 хувь чинь ашиг шимийг нь тодорхойлох гэж өөрөө хариулсан байхгүй юу. Ашиг шимийг тодорхойлох гэдэг чинь нөгөө үржил угсаанд нөгөө нэг эрсдэлтэй, эрсдэлгүй, тодорхойгүй гэдэгтээ яг ордог юм уу? Өөрөөр хэлбэл тодорхойгүй гэдэг чинь 30,8 хувь гэж үзэж байгаа юм уу? Ашиг шимийг нь тодорхойлох чинь уг нь өөр ойлголт биш үү?

Б.Бейсен: 5 номер хариулъя.

Ц.Мөнхнасан: Сая би хариултдаа дурдсан. Монгол адуу өөрөө ашиг шимийн, аливаа мал, амьтан ашиг шимийн чиглэлээрээ үүлдэр омог нь тодорхойлогдож явж байдаг. Уналга эдэлгээ, мах, сүүний ашиг шимийн чиглэлтэй адуу маань 30,8 хувьд нь яг аль ашиг шимийн чиглэл нь гол байгаа юм бэ гэдэг нь тодорхойгүй байна. Манайхыг Монгол үүлдрийн омгийн адууг мах, сүү, уналга эдэлгээний гэдэг дарааллаар бичдэг. Тэгэхээр бид энэ дарааллыг хэрхэн яаж тогтоох вэ гэдэг дээр 30,8 хувьд нь тодорхойгүй нөхцөл байна. Дахин тодруулах шаардлагатай гэдэг шинжээчдийн дүгнэлтийг л хэлж байгаа юм.

Б.Бейсен: Ганбаатар гишүүн тодруулъя. Ингээд дуусаж байна.

Г.Ганбаатар: Яах вэ энэ чинь ийм байхгүй юу өнгөрсөн 5209 юм байна шүү нэгдсэн тоо нь тэгвэл, 5700 биш. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд 5209 үржлийн адуу орж ирсэн юм байна. Хамгийн оргил үедээ 22 онд 937 үржлийн адуу орж ирсэн юм байна. Гэхдээ үүнийг гааль дээрээ үржлийн л гэж байгаа болохоос биш яг аль нь хурдных юм, аль нь махны чиглэлийнхийг нь гаалиас тодорхой авах боломжгүй байж яагаад нийт Монгол адууны адуун сүргийн 30,8 хувийг уналга эдэлгээ, мах, сүүний чиглэлээр тодорхойгүй гэж тодорхойлж байгаа юм бэ? Энэ чинь утгагүй зүйл байхгүй юу. Яг мэргэжлийн талаасаа та өөрөө мэргэжлийн хүн байлгүй дээ. Хилээр орж ирж байгаа тэр юуг тодорхойлоогүй байхад яаж нийт адуун сүргийнхээ 30,8 хувийг тодорхойгүй гэж? Магадгүй тэр 70 хувь нь хурдных байсан байж болно, 30 хувь нь махны чиглэлээр, одоо махны чиглэлийн адуунууд их үржүүлж байгаа шүү дээ. Гаднаас оруулж ирж байгаа тэр гаалийн мэдээ нь тодорхойгүй байхад яаж та нар энийгээ тогтоодог юм бэ?

Б.Бейсен: Ажлын хэсгийн гишүүн Отгонбаяр гишүүн хариулъя.

У.Отгонбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя ажлын хэсгийн гишүүний хувьд. Харин тийм таны хэлж байгаатай санал нэг байгаа юм. Ингээд маш олон зүйл тодорхойгүй болчихоод байгаа байхгүй юу одоо. Тийм учраас эхний ээлжид бүх адууныхаа асуудлыг нэг амыг нь нэг хумьж авъя. Тэр дундаа энэ үржил селекцэд орж байгаа чиглэлийнхээ, тэгээд хамаагүй энэний ар дээр нэг бүх юмнуудаа нэг хумьж аваад, бүх юмаа тодорхой болгочихсоны ар дээр тэр махны чиглэлийн, сая хэний Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа тэр сүүний чиглэлийн адуу юмнуудыг буцаагаад нээхэд чөлөөтэй болно гэж бодож байгаа. Тийм учраас бүгдийг нь хумьчихаад 10 жил хорих гэж байна гэж ойлгож, үгүй ээ тэрний чинь хооронд нэлээн зүйл болох юм билээ Бат-Эрдэнэ гишүүнээ. Одоо ингээд хаачихаар жишээ нь та бодоод үзээрэй, жилд энэ чинь дунджаар 560, 70 орчим адуу орж ирж байгаа үржлийн.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд асуулт асууж, дэгээ барья гишүүдээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу, нэрсээ өгнө үү? Идэрбат гишүүнээр тасаллаа. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Өнөөдрийн орж ирсэн асуудал нь эртээдийн тогтоолын төслийнхөө 4 дүгээр заалтыг хасъя гэж орж ирсэн юм. Тэр нь угаасаа тогтоолын 3 дугаар заалттайгаа буюу оруулж ирэхийг нь үнэхээрийн хязгаарлачихсан юм бол одоо хил гаалиар оруулдаг юмыг нь нарийсгана гэж ямар юм байх вэ дээ, давхардсан заалт байна гээд л хасаж байгаа юм билээ уг нь. Тэгээд энэ дэгээрээ явбал зүгээр байгаа юм гэж. Үгүй ээ ер нь хэдүүлээ янз бүрийн юм яривал ярихаар юм их байгаад байгаа юм. Энэ Хөдөө аж ахуйн яам ажлаа хиймээр байна. Тэр Малын удмын төв ажлаа хиймээр байна. Өөрсдөө төрийн бодлого тодорхойлоод, хууль батлаад өгчхөөд байхад ажлаа хийхгүй тэгээд нэг хэсэг уяачдын гэдэг юм уу, түрүүлж юманд хүрсэн улсуудын эрх ашгийг хангасан маягтай ийм балай юм оруулж ирдгээ ер нь болих ёстой. Улсын хэмжээнд үржлийн ажлын бодлого барих гэж байгаа бол тэрийгээ барь, барихгүй юм бол барихгүйгээ хэл.

Та нар энэ жил улсын баяр наадам хийгээд, энэ орон нутгийн баяр наадмууд чинь Монгол адууныхаа стандарт дээр тулгуурлагдаж явагдах ёстой шүү дээ. Тэр

ажил чинь хийгдээгүй. Сая та нар тэр шийдвэрийг ухраахаар маягтай юм гаргацгаасан байна лээ шүү дээ. Хууль нь 25 оны наадмаас эхэлж мөрдөхөөр заагдчихсан. Тэгээд ямар үндэслэлээр Их Хурал шийдвэрээ, хуулиа өөрчлөөгүй байхад та нар ямар юм үндэслээд тэр юуг өөрчлөөд байгаа юм бэ? Цаана нь энэ адууг уралдуулдаг гэдэг юм уу, явуулдаг юмнуудыг нь л хязгаарлачихвал наадах чинь аяндаа хязгаарлагдах эд байхгүй юу. Тэрнийгээ хийхгүй, хамгийн амар байж болох захиргааны шинж чанартай арга хэмжээгээр нь энийгээ хийж байгаа юм. Буцаад цаад талд чинь эргээд энэ зах зээлийн нийгэмд бид амьдарч байна. Арай ахиу бүтээгдэхүүн өгдөг, үнэ цэн ахиу эзэндээ авчирдаг юмыг хиймээр л байна шүү дээ. Махны чиглэлийн адуу Монгол адуунаас гарцын хувьд хамаагүй өндөр. Дээр нь адуунд өөрт нь нэг давагдашгүй боломж байгаад байгаа юм. Тэр нь өвчин эмгэг бага тусдаг, хилийн хорио цээр, хязгаарлалтыг давах чадамж нь өндөр.

Тийм учраас адууны мах экспортлох боломж Монголд байгаад байгаа байхгүй юу. Судлаад наадхыг чинь аваад байгаа улсууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг нь давхар бид хаачхаж байгаа байхгүй юу? Тэр бүс нутаг заасан заасан л гээд байна. Тэгээд тэр бүс нутагтаа л тэр үржлийнхээ ажлыг хязгаарлаач та нар. Тэгээд явж, явж бидний бодлого буруу байгаа байхгүй юу. Яагаад тал хээрийн адуу давхидаг юм гэдгийг анхнаасаа ясны бүтэц нь өөр байдаг юм тогтохдоо гэж хэлээд улсууд яриад байна шүү дээ наадах чинь, хурд нь тэгж гардаг юм гэж. Тэгэхээр бид хэд тогтдоггүй газар нь адуу үржүүлнэ гэж хэлчхээд, бүс нутаг зөрчигдөөд байна гээд хэлэхээр чинь тэгнэ шүү дээ. Тал газраа л аваачиж, тэр байгалийнх нь жамаар хурд илүү байх нөхцөлийг нь хангасан ясны тогтоц, бүтэцтэй байх юмыг нь л харж тэнд л үржүүлнэ шүү дээ. Бид хэд байгалийн хуулиас зөрсөн юм хийчихээр амьдралд хэрэгжихгүй байгаа байхгүй юу наадах чинь. Тэгээд энэ юм энэ тэрээ өөрчилье, зөв болгоё гэж ярихынхаа оронд жоохон маргадуу маягтай юм оруулж ирээд байгаа нь жоохон зовлонтой. Гэхдээ яах вэ энэ Монголын ард түмнийг нэг байгалийнхаа уур амьсгалыг дааж чаддаг тэсвэр чанартай адууг нь энэ генфондыг нь хадгалъя гэдэг үүднээс нүдээ аниад дэмжиж байгаа юм. Тэрнээс дэмжихээргүй тогтоол наадах чинь уг нь.

Б.Бейсен: Идэрбат гишүүн үг хэлье.

Ц.Идэрбат: Гишүүд маань нөгөө малын ашиг шим гэдэг талаас нь ярьж байгаа нь зөв. Гэхдээ энэ тогтоолыг гаргах гээд байгаа үндсэн шалтгаан бол энэ ашиг шим гэхээсээ илүүтэйгээр энэ Монгол өв соёл энэ бүх юмнуудаа л нэг авч үлдэхгүй бол ер нь болохоо байлаа гэдгийн л эхний алхмыг л энийг хийх гээд байгаа юм.

Уг нь сая Батжаргал гишүүний хэлж байгаа шиг Хөдөө аж ахуйн яам энэ рүүгээ нэг жоохон анхаараад, хөрөнгө мөнгөө тавиад, энэ асуудлаа нэлээн цэгцэлчихсэн бол ийм байдалд орохгүй байлаа л даа. Ингээд 4, 5 хоногийн дараа наадам болох гэж байна, үнэхээр тэгээд бүхэл бүтэн аймгийн наадамд 10 хэдхэн морь уралддаг энэ тэр гээд ингээд маш их сөрөг үр дагавар. Одоо та нар энэ янз янзын морины уяачдын групп дээгүүр гараарай. Тэр тагнуул, secret гэдэг азарга хүртэл гаргачихсан ингээд л байж байгаа байхгүй юу. Гэтэл Монгол адуу дэлхийд юугаар танигдсан гэхээр ердөө л тэр тэсвэр тэвчээр, тэр генд байгаа тэр онцлогоороо л танигдсан байдаг шүү дээ. Энэ асуудал чинь ингээд маш олон хугацааг ингээд ямар ч үр дүнгүй болж өнгөрснөөр энэ Монгол наадам чинь наадам биш болоод, наадам зохион байгуулахад залгуулаад тэр хэрүүлээс нь бараг хүн залхдаг болчихоод байна шүү дээ. Залхдаг болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ гишүүдийн ярьж байгаа тэр ашиг шим гэхээсээ илүүтэйгээр үүний цаана ийм л том асуудал бас явж байгаа юм л гэж би хэлэх гээд байгаа юм. Тэгээд Монгол төрийн наадам гэдэг бол би no naadam гэдэг шиг би тасрах ёсгүй гэж би боддог. Тасрахгүй байхын тулд энэ олон түмэндээ хүлээн зөвшөөрөгддөг ийм л байх ёстой. Гэтэл өнөөдөр бодит байгаа байдал маань маш төвөгтэй байдалд орчихоод байгаа юм.

Дараагийн нэг асуудал энэ зарим хүмүүс эд нар ярьдаг юм, энэ ингээд морь малаа дагаад хөдөө залуучууд байдаг шүү гэж. Тэгээд заримд нь их хөндий сонсогддог юм шиг байна лээ. Яг үнэндээ бол бас үнэн шүү. Яг үнэндээ үнэн. Тэгэхээр хөдөө аж ахуйн салбарын ажиллах хүч тэр залуу малчин энэ тэр гэж яригддаг юмнууд чинь үүнтэйгээ давхар уялдаад л явах юм байгаа юм. Сая Батжаргал гишүүний хэлж байгаа жоохон муйхардуу ийм арга хэмжээ, захиргааны арга хэмжээ авлаа гэдэг нь үнэн, үнэн. Гэхдээ өнөөдөр бид энэнээс өөр арга үнэндээ л харагдахгүй байна шүү дээ. Энийг сөхөж ярьдаг ч хүн алга. Гэтэл амьдрал дээр ямар байгаа вэ гэдгийг захын малчин залуу хэлж байна шүү дээ. Тэр нөгөө нэг хөх уяач гэдэг хүн чинь байхгүй болчихсон. Энэ чинь дагаад өв соёл хамаг юмнууд нь л байхгүй болж байна.

Тэгээд энэ чинь явсаар байгаад ген гэж байхгүй боллоо. Тэгээд энэ их зовлонтой юм байна лээ шүү дээ. Энэ нөгөө яаман дээрээс хэдэн квот өгдөг юм уу даа 200, 300, 400 ч юм уу жилдээ нэг квоттой ЗГ-ын тогтоолоор. Тэгээд л тэндээс нь тэдэн квот аваад өгөөч гэдэг амьтан салахгүй ёстой дарааны эд байна лээ шүү дээ наадах чинь. Тэгэхээр чи яадаг юм бэ гэхээр ердөө тэгээд л хэдэн азарга оруулж ирээд л, энд, тэндгүй мөнгө аваад л хээлтүүлэг хийгээд яваад байдаг. Сая Гантулга зөвлөхийн хэлж байгаа үнэн шүү дээ. Тэгэхээр тэгээд аргаа барсан алхам л гэж ойлгоорой. Тийм байгаа юм.

Харин тэр адууны махны экспорт нэмэгдэж байгаа, манайх гаргахад энэ нөгөө салаа туурайтны өвчин гээд Дэлхийн мал, эмнэлгийн байгууллагын тэр А жагсаалтад ордоггүй ийм махны экспорт нэмэгдүүлэх тал дээр яг махны чиглэлээр үржүүлж байгаа хүмүүс эд нар байгаа юм билээ. Тэрийг нь хэдүүлээ сая Отгонбаяр гишүүний хэлдэг эхлээд нэг цэгцэлж авч байгаад, тэр хүмүүсийн бизнесийг хааж болохгүй. Тэрийг нь харин яг мэргэжлийн Хөдөө аж ахуйн яам энэ дээр нэг гарц гаргалгаа гаргаж ирж нээж өгөхгүй бол яг энэ чиглэлийн юмнууд нь хаагдчих гээд байгаа юм. Тэгэхээр энэ зүгээр нэг хурдны бүх азаргыг хаана гэхээсээ илүүтэйгээр цаана нь нэг тийм юм байгаа юм. Дунд нь энэ адууны махны ашиг шимийг гаргах, нэмэгдүүлэх энэ бодлогыг хаяж болохгүй. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яам.../минут дуусав/

Б.Бейсен: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн үг хэлье.

Ц.Мөнхбат: Энэ мэдээж чухал хуулийн хэрэгжилтийн тухай бид ярьж байна л даа. Тэгээд манай зүүн бүсээс сонгогдсон гишүүд маань энэ ажлын хэсэгт нэлээн олуулаа орсон юм байна. Тэгээд энэ тал дээрээ нэлээн идэвхийлээд санаа бодол нэгтэй ажиллаж байгаа юм байна. Би та хэдийг дэмжиж байгаа. Яагаад гэхлээр манай бүс нутгийн зүүн талдаа манай адууны дийлэнх нь байдаг, хурдан нь ч байдаг. Гэхдээ нөгөө талд нь юу харагдаад байгаа юм гэхлээр зэрэг бүгдээрээ л нэг яам руугаа дайрсан болчих гээд байна л даа. Тэгэхдээ яамны бодит байдлыг нь хэлэхгүй болохгүй. Үнэнийг хэлэхэд, энэ дээр бол будилаан байгаа, байсан. Энэ өнгөрсөн тэр нэг жил болгон 500 хэдэн адуу ойролцоогоор оруулдаг юм байна.

Зарим жил 900-гаад адуу оруулдаг юм байна. Энэ адуунуудыг чинь хэдхэн компани хуваагаад авчихдаг, тэр квотуудаа зардаг. Тэрэнд нь ХААЯ-ныхан оролцдог гэдэг яриа л байдаг шүү дээ. Баримт гаргаад өгөөрэй гэвэл гаргаад өгч чадна.

Тэгэнгүүтээ хэдэн адуу оруулаад одоо боллоо, энүүгээрээ 10 жил явчихъя гэдэг ийм ард нь нэг ийм зүйл юм яваад байгаа юм биш биз гэж сая надад зүгээр сэтгэгдэл төрсөн юм. Сая энэ Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаа оргүй үг биш, зөвхөн хурдны адуун дээр фокуслаад байна. Сая энэ гишүүдийн хэлээд байгаа бид энэ адууны махны экспортыг нэмэгдүүлэх тухай энэ Евроазийн гэрээтэй холбоотой манайх адууны мах нийлүүлэх боломжтой, Станы орнууд руу нийлүүлэх боломжтой гээд л зөндөө олон зүйл яриад байдаг. Тэгэхээр зэрэг одоогийн байгаа бидний хүчин чадал манай адууны энэ генетик энэ зүйлүүд чинь энэ нөхцөлийг чинь бүрэн дүүрэн хангаж чадах юм уу, үгүй юү гэдэг ийм л асуудлууд дагаад явах нь байна шүү дээ. Тэгэхээрээ зэрэг дахиад хэлье. Энэ асуудлыг дэмжье. Гэхдээ манай яамныхан хойшдоо анхаараарай. Бид энэ хяналтыг үргэлж бид тавина. Анхаарал үргэлж хандуулна. Өмнө нь явагдаж байсан танайх тэр шагнал урамшил зардаг үрдэг, өөрсдийнхөө уяачдад шагнал урамшил өгдөг нэг энэ байдлаа больцгоогоорой нөхдүүд ээ. Энийг хатуу хэлмээр байна.

Б.Бейсен: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ ажлын хэсэгт энэ Мөнхнасан гээд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга гэж байна, окей. Энэ Батбаатар, Гантулга гишүүний зөвлөх, гишүүний зөвлөх, Балжинням энэ Мал эмнэлгийн газрын Тархвар зүй, мэдээлэл судалгааны газрын гэж байна. Энэ ажлын хэсэгт ер нь мэргэжлийн хүмүүсээ оруулж бай л даа нэг.

2 дугаарт та бүхэн хар даа хэдэн уяачдын лоббинд орж байгаагаа нуухын тулд тэрнээсээ ичээд бултахын тулд яг үнэндээ энэ адууны үржлийн тухай асуудлыг бүхэлд нь биш, зөвхөн том үржлийн малын үржил дотроосоо зөвхөн адууны үржлийг ингэж зогсооно гэж байж болохгүй шүү дээ. Тийм л байсан юм бол энд хурдны адуу гэдгээ шууд заачих л даа. Юунаасаа ичээд байгаа юм бэ тэгвэл, тэрийгээ нэгмөсөн хурдны адууг 10 жилийн хугацаагаар хаачихъя. Хангалттай гэдгээ л шууд гаргаад ир л дээ. Ингэж үржил хийж болохгүй шүү дээ. Энэ мал, хэн ээ Мөнхнасан? Ийм бодлого та нар барьж болохгүй шүү дээ. Би танай яамны тэр малын эрүүл мэндтэй холбоотой асуудлын мэргэжилтнүүд тэр хариуцаж байгаа хүмүүстэй би мэдэхгүй, тэр хүмүүсийг ер нь соль гэдэг ийм шаардлага тавьдаг, чадваргүй байна гэж хардаг. Өнөөдөр өөрсдөө өөрөө Мөнхнасан үнэхээр чадваргүй байна гэж би харж байна. Би шулуухан хэлье, соль гэдэг шаардлага би тэр сайдад чинь тавина. Ийм юм яриад зогсоод байж болохгүй шүү дээ. Шулуухан хэл л дээ тэр лоббинд орчихсон юм би, тэгээд л энэ уяачдын хэдэн лоббинд орсон юм, тэгээд энэ бүх адуугаа нэг ийм байдал руу оруулчихлаа гээд чи, наадах чинь гэмшил байх ёстой байхгүй юу ард талд чинь.

Би эндээс адуун сүргийг, үржлийн адуу гэдэг дотор хурдныг л гэж үгийг нь шууд оруулж ирмээр ийм санал оруулмаар байна үнэндээ. Тэгээд энэ дотор халхавч хийгээд малын генетик, нөөцийн асуудлуудыг томоор нь оруулж ирчхээд, тэгчхээд тэр дотроосоо ганцхан заалтыг нь болохоор адууныхаа асуудлыг ингээд сугалаад явж байдаг. Тэр адуу мэдэхгүй, би тэр адуутай чинь нэг их ноцолдохоо

бол болиод удаж байна. Намайг тэр лобби талаас нь хараад байж магадгүй, үгүй. Хамгийн гол нь генетик нөөцтэй, малын генетик нөөцтэй холбоотой энэ том асуудлыг сөхөж ирсэн бол сөхсөн шиг сөхөөд цаашаа явах хэрэгтэй байна. Сөхсөн шиг сөхөөд явах хэрэгтэй байна шүү. Энийг дандаа яриад байгаа шүү бид. Тэгээд энэ том асуудлыг сөхчхөөд, тэрнийхээ ар тал дээр ийм жижигхэн асуудал оруулж ирээд явж байхдаа ичих хэрэгтэй шүү дээ энэ яамныхан.

Б.Бейсен: Бадамсүрэн гишүүн үг хэлье.

М.Бадамсүрэн: Энэ дэлхийн бөмбөрцгийн 195 улс байна. Энэ улс орнуудаас төрийн сүлдэндээ Монгол морио залсан ганцхан улс манай Монгол Улс. Тэгээд 2-т нь энэ та бүхэн санаж байгаа байх Монгол адууны өвөг тахийн удам тасраад тэгээд гадаадаас бөөн юм болж ингээд Монгол тахийг Монгол эх орондоо авчирч байсан энэ түүх нэн саяхных шүү. Тэгэхээр эндээс юу харагдаад байна гэхээр энэ Монгол адууг хамгаалах, удмын санг нь хамгаалах гэдэг асуудал энэ Монголчуудын хамгийн чухал асуудал. Тэгээд би тахь шиг болох вий гэж санаа зовж байгаа учраас хэлж байгаа юм. Яг үнэндээ энийг олон Монгол адуучид, жирийн Монгол залуучууд, жирийн Монгол малчид хэлж байгаа. Та бүхэн санаж байгаа. Манай Дундговийн Засаг дарга байсан Мөнхбат дарга санаж байгаа. Дундговийн Улаанхүү гээд уяач, Монгол сайхан уяач төрийн наадамд үрээ түрүүлүүлэхэд Монголын ард түмэн ямар их баярлаж байна. Энэ чинь ард түмэн энийг хүсээд байгаа байхгүй юу. Ерөөсөө ингээд жирийн хөдөө амьдарч байгаа малчин залуучуудад улсын наадамд, аймгийн наадамд, бүсийн наадамд морь айрагдуулах боломж үнэхээр байхгүй болсон. Дандаа хөрөнгөтэй, мөнгөтэй, чадалтай чансаатай улсууд хэдэн зуун сая, хэдэн тэрбумаар нь үнэтэй адууг оруулж ирдэг, үнэтэй адуу авдаг, үржүүлэг хийдэг. Тийм учраас энэ маргаан салахгүй байгаад байгаа юм.

Энэ чинь Монголын тусгаар тогтнолын баяр үндсэндээ 7 сарын 11, 12-ны өдөр буюу Монгол Улс ардын хувьсгалаа ялж, тусгаар тогтнолоо мандуулсан энэ өдөр Монголын ард түмний баяр цэнгэл наадам болдог. Гэтэл энэ баяр цэнгэл наадам одоо эрлийз адуу, Монгол адуу гэдэг энэ маргааны үндсэн дээр үндсэндээ маш их хэрүүл уруултай маш их асуудалтай болдог болсон. Тэгээд энэ үндэсний энэ баяр наадам тусгаар тогтнолын баярын мөн чанар алдагдаад байгаа нэг хүчин зүйл байгаа. Тийм учраас энэ зүйлийг би энэ Монголын морин спорт, уяачдын холбоо болон Үндэсний морин спорт, уяачдын холбоо дэмжиж саналаа өгсөн гэж ойлгож байгаа энд. Энэ уяачдын эрх ашгийг хамгаалж байгаа олон Монгол уяачдынхаа эрх ашгийг хамгаалж тэдний дуу хоолойг илэрхийлж байгаа 2 том төрийн бус байгууллага өөрсдөө энэ ажлын хэсэгт орж ажиллаад, өөрсдөө саналаа өгөөд, дэмжиж байгаагаа илэрхийлнэ гэдэг бидний хувьд хамгийн хүндэтгэн үзэх шалтгаан мөн үү гэвэл мөн гэдгийг бид ойлгох хэрэгтэй.

Манай зүүн бүсийн Сүхбаатар аймаг гэхэд хурдны өлгий. Сүхбаатар аймгийн малчид, Хэнтий аймгийн адуучид, малчид, Дорнод аймгийн адуучид, малчид хамгийн их хадгаламжтай байдаг байсан. Одоо энэ боломж байхгүй болсон. Маш их мөнгө энэ импортын азарганд хэдэн тэрбум доллар гадагшаа урсаж байна. Энэ ингээд Монгол Улсын валютын нөөцөд нөлөөлж байгаа юу нөлөөлж байгаа. Мөн дараагийн нэг зүйл энэ адууны олон улсын хорио цээрт ийм өвчин байдаг юм байна. Энэ Монголд хараахан бүртгэгдээгүй байгаа. Энэ сайн. Энэ импортын адуу замбараагүй байвал нэг өдөр Монголд энэ олон улсын хорио цээрт мах экспортолж болдоггүй ийм өвчин гарах вий гэдэг болгоомжлол байгаа.

Энийг олон мэргэжлийн байгууллагууд хэлж байгаа. Ажлын хэсгийн хурал дээр энэ талаар танилцуулсан. Монгол Улсын экспортолж байгаа махны тийм 30-аас 40 хувь орчим нь үндсэндээ адууны мах байгаа. Энэ хаврын цагт хамгийн их борлуулалтад орж байгаа мах бол адууны мах. Тэгэхэд энэ адууны махны борлуулалт дээр энэ битүү туурайтай амьтан хамгийн их өвчингүй байдаг, ийм тэсвэр хатуужилтай ийм Монгол адуу ийм эрсдэл үүсэх үү гэвэл үүснэ.

Тийм учраас импортын адуун дээр тодорхой хугацаанд дотооддоо энэ асуудлаа цэгцлэх, дотооддоо энэ хяналт шалгалтаа тодорхой болгох, энэ цусанд нь болсон генд нь шинжилгээ хийх энэ хүртэл хугацаандаа энийг тодорхой хугацаагаар импортлохыг тэглэх нь зөв зүйтэй ажил гэдгийг л үндсэндээ Монголын ард түмэн Монгол.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ тогтоол, тогтоолын төслийг тараачихсан байгаа гишүүдэд бүгдэд нь. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй гишүүд. Тийм. Тогтоолын, гишүүд тогтоолын төслийг тараачихсан учраас, 5 заалттай байсан байхгүй юу тэр үед, 4 дүгээр заалтыг хасъя гэдгээр одоо санал хураалт явуулъя. Хассанаа өгсөн. Харин тэгж байгаа шүү дээ, хассанаа өгсөн байхгүй юу та бүгдэд. Тийм. Тэгж танилцууллаа шүү дээ би сая. Хасчхаад, яг шинэ юуг нь та бүгдэд тараасан байхгүй юу, тэрийг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя гэсэн шүү дээ сая. Тийм.

Шинэ тогтоолын төслийг тараачихсан шүү дээ. Одоо тэрнийгээ дэмжье гэдгээрээ санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй. Санал хураалт. Тогтоолын төсөл, гишүүд жаахан чимээгүй байж байгаарай. Тогтоолын төсөл 68,8 хувиар дэмжигдлээ. Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ганхүлэг гишүүн танилцуулна.

13.21 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

